

# Хараат бус тайлан: Монгол улс Эцсийн тайлан 2016-2018

---

Загдрагчаагийн Батболд, Хараат бус судлаач

## Гарчиг

Тойм: Монгол улс	2
Үнэлгээний тухай	6
Зорилтуудын хэрэгжиулт	8
1. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликацийн	
	10
2. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	14
3. Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо	18
4. Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх	21
5. Хэвлэл мэдээллийн эрх зүйн таатай орчныг бий болгох	24
6. Авиалгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	27
7. Гадаад зээл, тусlamжийн ил тод байдал	30
8. НӨАТ-ын цахим бүртгэл	32
9. Шилэн дансны системийг сайжруулах	35
10. Засгийн газрын худалдан авах ажиллагааг нээлттэй болгох	38
11. Нийтийн баялгийг ашиглах гэрээний ил тод байдал	41
12. Байгалийн баялгийг ашиглах этгээдийн эздийн мэдээллийн ил тод байдал	44
13. Төрөөс компаниудын зөвшөөрөл, санхүү, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, шуурхай болгох	47
Аргачлал	50



## Тойм: Монгол улс

Хараат Бус Тайлалгналын Механизм (ХБТМ) Эцсийн Тайлан (2016-2018)

Монгол улсын хоёрдугаар Үйл Ажиллагааны Үндэсний Төлөвлөгөөнд (YAYT) нээлттэй засгийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэвлэл, мэдээллийн эзэмшигчдийн ил тод байдал, улс төрийн санхүүжилт, ашиг хүртэгч эзэд болон олборлох салбарын гэрээний ил тод болгох, шилэн дансны системийг сайжруулах зэрэг асуудлыг багтаасан болно. Хугацааны эцэст улс төрийн өөрчлөлтүүд, зөвлөлдөх үйл явц бараг явагдаагүй, зорилтуудыг хариуцсан зарим байгууллагуудын идэвхгүй байдлаас шалтгаалан хэрэгжилтийн түвшин тааруу байв. Монгол улсын хувьд нээлттэй засгийн тухай сурталчлан таниулах, хэрэгжилтийг хянах ажлын хэсгийг идэвхжүүлэх, засгийн газрын агентлагуудыг нэмж оролцуулах, зорилтуудын хүрэх үр дүнг илүү нарийн тодорхойлох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд илүү анхаарах хэрэгтэй байна.

Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ) нь төр, засгийн зүгээс иргэд, олон нийтийн тусын тулд ил тод байдлыг хангах, иргэдийг хүчтэй болгох, авлигатай тэмцэх, засаглалыг бэхжүүлэх зорилгоор шинэ технологийг нэвтрүүлж ашиглахад чиглэсэн, олон улсын сайн дурын санаачлага юм. Хараат Бус Тайлалгналын (ХБТ) механизм нь НЗТ-д оролцогч улс дахь хэрэгжилтын явцыг дүгнэн шинжилдэг. Энэхүү тайлан Монгол улсын хоёрдугаар YAYT-ний 2017 оны 10-р сараас 2018 оны 6-р сарын хоорондох хоёр дахь жилийн хэрэгжилтийг хамарсан ба мөн 2018 оны 8-р сар хүртэлх зарим холбогдох үйл явдлыг багтаасан болно.

Монгол улс энэхүү 2-р YAYT-гээ 2016 оны 2-р сараас 6-р сарын хооронд боловсруулан гаргасан. ЗГХЭГ Монголын НЗТ-ийн үйл явц, зорилтуудыг зохицуулан ажилладаг. НЗТ-ийн Үндэсний Зөвлөл нь төрийн яамд, агентлаг болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрддэг. Хэдийгээр иргэний нийгэм YAYT-г боловсруулахад идэвхтэй оролцсон боловч хэрэгжүүлэх үйл явцад цөөн хэдэн байгууллага л оролцсон болно. Мөн иргэний нийгмийн төлөөлөл НЗТ-ийн ажлын хэсэгт орсон боловч энэ ажлын хэсэг нь хэрэгжилтийн явцад ихэнхдээ идэвхгүй байлаа. Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) хэрэгжилтийн хугацаа дуусах үед хоёр дахь YAYT-ний хэрэгжилтийн талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. 2-р YAYT-г хэрэгжүүлэх хугацаанд Монгол улсад хэд хэдэн улс төрийн хүрээний өөрчлөлтүүд гарч засгийн газрууд солигдож байсан нь ЗГХЭГ-ыг НЗТ-ийн үйл ажиллагаанд анхаарч ажиллахад нь саад болов. ЗГХЭГ өөрийн үнэлгээний эцсийн тайланг гаргаагүй болно.

Хүснэгт I. Товч		
	Дунд хугацаа	Эцсийн
Зорилтын тоо	13	13
Хэрэгжилтийн түвшин		
Бүрэн хэрэгжсэн	0	3
Ихэнх нь	3	1
Хязгаарлагдмал	6	9
Эхлээгүй	4	0
Дараах шаардлагыг хангасан		
НЗТ-ийн үнэт зүйлстэй тодорхой хамааралтай	13	13
Томоохон үр нөлөө бүхий	3	3
Ихэнх нь буюу бүрэн хэрэгжсэн	3	4
Гүрвүүланг нь (⊗)	1	1
Засгийг нээлттэй болгосон уу?		
Томоохон	3	
Дорвийтой	0	
Цааш үргэлжилсэн байдал		
Дараагийн YAYT-нд үргэлжлэн орсон зорилтын тоо		4

2018 оны хоёрдугаар хагаст 3-р YAYT-г боловсруулах төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн төлөөллийн оролцоотой олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалтууд зохион байгуулагдсан. Гэвч YAYT-гөө батлан гаргах эцсийн хугацаа болох 2018 оны 8-р сарын 31-нөөс хойш 4 сар өнгөрсний дараа буюу 2019 оны I-р сарын I-ний байдлаар гаргаагүй байсан нь НЭТ-ийн үйл явцыг зөрчсөн явдал болсон. Тийм учраас Монгол улс НЭТ-ийн “тэгш жил”-ээс шилжин “сондгой жил”-ийн оролцогч болов. Үүний дараа 2019 оны I-р сарын 31-нд ЗГХЭГ Монгол улсын 3-р YAYT-г баталсан. Энэхүү төлөвлөгөө нь төрийн үйлчилгээ, төсөв санхүү, байгалийн баялгийн удирдлага зэрэг салбарыг хамарсан 13 зорилтоос бүрдэж байна. 4 зорилт нь өмнөх YAYT-нөөс үргэлжилж байгаа бол 9 нь шинэ зорилт болно.

## Хэрэгжилтийн үеийн зөвлөлдөх үйл явц

НЗТ-ийн оролцогч улсууд YAYT-гөө боловсруулах болон хэрэгжүүлэх явцдаа зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулах ёстай. 2-р YAYT-г батлагдсаны дараа Үндэсний зөвлөл хэрэгжилтийг хянах зорилго бүхий олон талт хэлэлцүүлгийн форумын үүргийг гүйцэтгэх шинэ ажлын хэсгийг байгуулсан. Гэвч энэхүү өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг YAYT-ний үед ерөнхийдөө идэвхгүй байлаа. Мөн хоёр том сонгууль болж, дараагаар нь шинэ томилгоонууда явагдсан нь засгийн газарт НЗТ-ийн үйл ажиллагаанд зохих ёсоор анхаарлаа хандуулж ажиллахад саад болсон.

Хэрэгжилтийн үе шат дуусах дөхсөн үед буюу 2018 оны 5-р сарын 23-нд Нийгмийн Дэвшил – Эмэгтэйчүүд ТББ-ын санаачлагаар иргэний нийгмийн байгууллагууд зорилтуудын хэрэгжилтийг аүгнэн хэлэлцэх олон нийтийн хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. Иргэний нийгэм болон төр, засгийг төлөөлсөн 35 хүн энэхүү уулзалтанд оролцсон. ИНБ-уудын төлөөлөл зорилтуудын хэрэгжилтийг танилцуулж, оролцогчид санал, зөвлөмжөө илэрхийлсэн болно. ЗГХЭГ-ийн төлөөлөл энэхүү уулзалтанд мөн оролцсон. Энэхүү уулзалтын дараа Нийгмийн Дэвшил – Эмэгтэйчүүд ТББ-ын санаачлагаар 2018 оны 6-р сард ИНБ-ууд 2-р YAYT-ний хэрэгжилтэнд мониторинг хийсэн. Энэхүү мониторинг, зөвлөмжүүдэд үндэслэн засгийн газар ямар нэгэн хариу арга хэмжээ аваагүй.

Хүснэгт 2: Хэрэгжилтийн үеийн зөвлөлдөх үйл явц

Байнгын олон талт форум	Дунд хугацаанд	Эцсийн
I. Форум бий болсон уу?	Тийм	Тийм
2. Байнгын уулзалт болсон уу?	Үгүй	Үгүй

Хүснэгт 3: Хэрэгжилтийн үеийн олон нийтийн нөлөөллийн түвшин

ХБТМ Олон Улсын Олон Нийтийн Оролцооны Нийгэмлэгийн “Оролцооны спектр”-ийг НЗТ-д хэрэглэдэг.<sup>1</sup> Энэхүү спектр нь YAYT-ний агуулгын олон нийтийн нөлөөллийн боломжит түвшинг харуулдаг. НЗТ-ийн хувьд ихэнх улсууд “хамтрах”-ыг зорих хэрэгтэй.

YAYT-ний хэрэгжилтийн үеийн олон нийтийн нөлөөллийн түвшин	Дунд хугацаа	Эцсийн
Эрх мэдэл өгөх	Засгийн газар олон нийтийн төлөөлөлд шийдвэр гаргах эрх мэдлийг олгосон.	
Хамтрах	Хэлэлцүүлэг тогтмол өрнөж, хөтөлбөрийг боловсруулахад олон нийт оролцсон.	
Оролцуулах	Засгийн газар олон нийтээс ирсэн саналыг хэрхэн тусгахаа мэдэгдсэн.	
Зөвлөлдөх	Иргэд саналаа өгөх боломжтой.	✓

<b>Мэдээлэх</b>	Засгийн газар олон нийтэд YAYT-ний талаар мэдээвлэл өгсөн.		
<b>Хэлэлцүүлэг болоогүй</b>	Хэлэлцүүлэг болоогүй	✓	

<sup>1</sup> IAP2 Олон нийтийн оролцооны спектрум, Олон улсын олон нийтийн оролцооны холбоо, 2014, [http://www.iap2.org/resource/resmgr/foundations\\_course/IAP2\\_P2\\_Spectrum\\_FINAL.pdf](http://www.iap2.org/resource/resmgr/foundations_course/IAP2_P2_Spectrum_FINAL.pdf)

## ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

ХБТМ-ын судалгаанд ашиглагдсан үзүүлэлт болон аргачалтай ХБТМ-ийн гарын авлагаас танилцаж болно.<sup>1</sup> Уншигчдын хувьд анхаарал татахуйц үзүүлэлт бол “одтой зорилт” (⊕) юм. Одоор тэмдэглэгдсэн үзүүлэлтүүд нь НЗТ-ийн үлгэр жишээ зорилтууд болно. Одтой тэмдэглээтэй болохын тулд зорилтууд дараах хэдэн шаардлагыг хангах ёстай. Үүнд:

- Өндөр эсвэл дунд зэргийн ач холбогдолтой байна. Боломжит нөлөөллийг үнэлэх үнэлгээ нь тодорхой байх ёстай.
- Нээлттэй засаглалын үзэл санаатай хамаарал нь тодорхой байна. Тухайлбал мэдээллийн хүртээмжтэй байдал, иргэдийн оролцоо, төрийн хариуцлагатай байдал зэрэг НЗТ-ийн үнэт зүйлсийн ядаж нэгд нь хамааралтай байна.
- Бүрэн хэрэгжсэн тохиолдолд томоохон үр нөлөөтэй байх.<sup>2</sup>
- Засгийн газар YAYT-г хэрэгжүүлэх явцад тухайн зорилтын хувьд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарган “ихэнх хэсэг нь” эсвэл “бүрэн” биелсэн байх ёстай.

Хэрэв YAYT хэрэгжиж дуусах үед од үнэлгээтэй зорилтын ихэнх хэсэг нь эсвэл бүрэн хэрэгжээгүй бол одтой статусаа алдах болно.

Дунд хугацааны тайланд Монгол улсын YAYT нэг одтой зорилттой байсан. YAYT хэрэгжиж агуусахад мөн нэг зорилт од үнэлгээтэй хэвээр байна.

Энэхүү тайланд ХБТМ-ын цуглуулсан тоо, баримтыг хүснэгт хэлбэрээр оруулсан болно. Монголтой холбогдох бүрэн хэмжээний тоо, баримтыг OGP Explorer-с үзнэ [www.opengovpartnership.org/explorer](http://www.opengovpartnership.org/explorer).

### Засгийг нээлттэй болгосон уу? үзүүлэлтийн тухай

Засгийн газрын ажлын арга барил хэрхэн өөрчлөгдсөнийг дүгнэхийн тулд эцсийн тайланд “Засгийг нээлттэй болгосон уу?” гэсэн шинэ хувьсагч орох болсон. Зорилтыг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэсэн ажил, гарсан үр дүнг дүгнэхээс гадна энэхүү хувьсагч нь засгийн газрын ажлын арга барил хэрхэн өөчрлөгдсөнийг авч үздэг.

НЗТ-ийн зорилтууд ихэнх тохиолдолд ерөнхий утгатай, нээлттэй засагтай хэрхэн холбогдож буй нь тодорхой бус байдаг боловч улс төрийн дорвитой шинэчлэл болдог. Харин үүний эсрэг зарим зорилтууд НЗТ-тэй хамаарал сайтай, дорвитой өөрчлөлт хийх боломжтой байдаг ч хэрэгжсэнийхээ дараа засгийг нээлттэй болгож чадаагүй байдаг. “Засгийг нээлттэй болгосон уу?” хувьсагч нь энэхүү асуудлыг авч үздэг.

“Засгийг нээлттэй болгосон уу?” хувьсагч нь засгийн газрын ажлын арга барилд ямар өөчрлөлт гарсаныг дараах үзүүлэлтүүдийн дагуу дүгнэдэг. Үүнд:

- Муудсан: зорилтын хүрээнд авсан арга хэмжээнүүдийн үр дүнд засгийн газрын нээлттэй байдал муудсан
- Өөрчлөгдөөгүй: засгийн газрын үйл ажиллагаа өөрчлөгдөөгүй
- Бага зэрэг: нээлттэй байдлын түвшинд бага зэрэг нөлөөлж чадах өөрчлөлт
- Томоохон: холбогдох бодлогын хүрээнд засгийн газрын нээлттэй байдалд ахиц дэвшил гаргасан ч хамрах цар хүрээний хувьд хязгаарлагдвал
- Дорвитой: холбогдох бодлогын хүрээнд засгийн газрыг нээлттэй болгож өмнөх ажил явуулдаг арга барилыг өөрчилсөн.

Энэхүү хувьсагчийг дүгнэхийн тулд YAYT-г хэрэгжүүлж эхлэхэд ямар байдалтай байсныг тогтооно. Дараа нь засгийн газрын нээлттэй байдал хэрхэн өөрчлөгдсөнийг гарсан үр дүнгээр нь тооцно.

Үншигчид судалгааны хувьд зарим нэг хязгаарлалт бийг анхаарахыг хүсье. ХБТМ-ын эцсийн тайлан хэрэгжүүлэх үе шат дуусаад хэдхэн сар өнгөрсний дараа гардаг. Хувьсагч нь хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэний эцэст засгийн газрын ажлын арга барилд нээлттэй байдлын зүгээс ямар үр дүн гарсаныг авч үзнэ. Нарийн төвөгтэй аргачлал, цаг хугацаанаас хязгаартай байдлаас шалтгаалан энэхүү тайлан нь үр нөлөөг үнэлэх зорилго агуулаагүй болно.

---

<sup>1</sup> IRM Procedures Manual, <https://www.opengovpartnership.org/documents/irm-procedures-manual/>

<sup>2</sup> Олон Улсын Экспертүүдийн Зөвлөл шалгуураа 2015 оноос өөрчилсөн.

## Зорилтуудын хэрэгжилт

### Зорилтуудын ерөнхий тойм

НЭТ-ийн хүрээнд улс орнууд 2 жилийн хугацаатай YAYT-г боловсруулан зорилтуудаа тавьдаг. Доорхи хүснэгтэнд зорилтуудын хэрэгжилтийн түвшинг хураангуйлан мөн “Засгийг нээлттэй болгосон уу?” үзүүлэлтийг харуулж байна. Дунд хугацаанд бүрэн хэрэгжсэн зорилтуудын хувьд дунд хугацааны тайланд орсон мэдээллийн хураангуйг оруулахын зэрэгцээ “Засгийг нээлттэй болгосон уу?” үзүүлэлт дээр төвлөрч дүн шинжилгээ хийсэн болно. Эдгээр зорилтуудын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Монгол улсын дунд хугацааны хараат бус тайлан (2016-2017) - гаас үзнэ үү.

Монгол Улсын 2-р YAYT нь НЭТ-ийн 5 үндсэн зарчимаас 4 буюу төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн үйл ажиллагаанд шударга байдлыг нэмэгдүүлэх, төрийн нөөц, эх үүсвэрийг үр дүнтэйгээр үйирдах, компанийн хариуцлага, эргэн тайлагналыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлийн 13 зорилтыг багтаасан болно. 1-р зорилт: II-II төв, 7-р зорилт: гадаадын зээл, тусlamжийн ил тод байдал, 9-р зорилт: шилэн дансны систем зэрэг нь эхний YAYT-нөөс үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр орсон.

### Хүснэгт 4: Зорилт бүрийн хэрэгжилтийн ерөнхий тойм

Зорилт	Тодорхой байдал	НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал			Боломжит үр нөлөө	Хэрэгжсэн байдал	Дуна хугацаа Эцсийн хугацаа	Засгийг нээлттэй болгосон уу?
		Үгүй	Бага	Дуна				
I. Засгийн газрын II-II төв		✓			✓	✓	Бурэн	Мүүласан Өөрчлөгдөөгүй
★ 2. Боловсрол, эрүүл мэндийн салбар дахь нийгмийн эгэх хариуцлага		✓			✓	✓	✓	✓
3. Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн орлцоо	✓				✓	✓	✓	✓
4. Улс төрийн намын	✓				✓	✓	✓	✓

санхүүжилтийн ил тод байдал													
5. Хэвлэл мэдээллийн таатай орчныг бий болгох		✓		✓	✓			✓		✓	✓		
6. Авиалгатай тэмцэх үндэсний хөтөлбөр		✓			✓		✓			✓		✓	
7. Гадаадын зээл тусламжийн ил тод байдал		✓		✓				✓		✓	✓		
8. НӨАТ-ын цахим бүртгэл		✓		✓	✓			✓		✓	✓		
9. Шилэн дансны систем		✓		✓				✓		✓	✓		
10. Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал		✓		✓				✓		✓	✓		
11. Нийтийн баялагийг ашиглах гэрээний ил тод байдал		✓		✓	✓			✓		✓			
12. Ашиг хүртэгч эздийн ил тод байдал		✓		✓				✓		✓	✓		
13. Төрийн өмчит компаниудын ил тод байдал			✓	✓				✓		✓	✓		

## **I. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашн**

### **Зорилт:**

Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II төвийн үйлчилгээнд “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашн нэвтрүүлэх, цахимжуулах, иргэдэг сурталчлах, ашиглалтыг идэвхжүүлэх.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II төв 2013 оноос хойш тасфалтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2014-2016 оны МУ-ын НЗТ-ийн ЯАҮТ-ний хэрэгжилтээр “og” үнэлгээ авсан юм. II-II төв нь иргэдээс ирсэн санал, гомдолын мөрөөр хариу өгдөг ч энэ нь үйлчилгээг сайжруулах түүхэц болж чадахгүй байна. II-II төвийн үйлчилгээний ил тог байдал, хүртээмж, чанарыг үйлчилгээ хүртэгч иргэдээр үнэлүүлдэг, үйлчилгээ үзүүлэгч байгууллагагаа хариуцан тайллагнагааг тогтолцоог сүүлийн үеийн дэвшилтээт технологийг ашиглан цахимжуулах зайлшгүй шаардлага гарч байна.

### **Үндсэн зорилго:**

Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашн нэвтрүүлснээр төрийн үйлчилгээ иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцэн ил тог, чанаартай, шуурхай болно.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

- 1.1. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II төвийн өнгөрсөн 2 жилийн үйл ажиллагаанд хөнгөнгийн үнэлгээ хийлгэх.
- 1.2. Хөнгөнгийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II төвийн үйлчилгээ, үр дүнг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх техник, технологийн арга зам, хувилбарыг тодорхойлох.
- 1.3. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II төвийн үйлчилгээнд тус төвийн апликашн нэвтрүүлэх техник, контентыг боловсруулж бэлэн болгох.
- 1.4. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашны түршилт хийх.
- 1.5. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашны update хийх.
- 1.6. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашн сервисийн нээлтийн ажиллагаа зафлах.
- 1.7. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашныг олон нийтэд сурталчлах, ашиглах, заавар өгөх.
- 1.8. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашн сервисийн үйл ажиллагааг тогтвортой ажиллуулах
- 1.9. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын II-II” төвийн апликашн сервисийн үйл ажиллагааны хөнгөнгийн үнэлгээг ТББ-аар хийлгэж, дүгнэлт гафтуулах, олон нийтэд мэдээлэх.

### **Хэрэгжүүлэгч байгууллага:** ЗГХЭГ

**Хамтран ажиллах байгууллагууд:** Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага /бүх яам, агентлаг, нийслэл, аймаг, сум дүүргийн ЗДТГ/, Ардчиллын боловсрол төв ТББ, Нийгмийн хариуцлагын төлөөх түншлэл, холбогдох бусад ИНБ

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал			Боломжит үр нэлэө			Хэрэгжсэн байдал		Дунд хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?						
	Үгүй	Бага	Дунаа	Их	Мэдээлийн хүргтээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тоа байдал, хариуцагатай байдлыг сайжруулах технологийн	Үгүй	Бага	Дунаа	Томоохон	✓ Эхлээгүй	Агуул	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвитой
Зорилт																					
I. Ерөнхий дүн	✓				✓	✓	✓	✓	✓	✓			✓	✓				✓		✓	

## Зорилго

Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын I-I-I төвийн апликацийн нэвтрүүлж төрийн үйлчилгээг ил тод болгох. I-I-I төв нь иргэдээс төрийн үйлчилгээний талаар ирсэн санал хүсэлтийг хүлээн авч холбогдох төрийн байгууллагад хариу арга хэмжээ авахуулах зорилгоор явуулдаг. I-I-I төв нь ирсэн санал хүсэлтийг бүрэн харуулдаг ч төрийн байгууллагын зүгээс хэрхэн шийдвэрлэсэн мэдээлэл, иргэдэд түүнийг хянах механизм байдаггүй. Үүнээс гадна апликацийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээг ТББ-аар хийлгэж, I-I-I төвийн өнгөрсөн 2 жилийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглээний үйл ажиллагааг сайжруулах зорилготой.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Эхлээгүй

Энэхүү зорилт YAYT-ний эхний жилд хэрэгжиж эхлээгүй. Гар утасны апликацши хамгийн сүүлаа 2015 оны 6-р сард шинэчлэгдсэн болно.<sup>1</sup> Хэдийгээр I-I-I төв санал, гомдол авсан хэвээр боловч цахим хуудас нь шинэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг болоогүй.<sup>2</sup>

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны хараат бус явцын тайлангаас үзэж болно.<sup>3</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

2016 оны УИХ-ын сонгуулийн дараа байгуулгасан шинэ засгийн газар I-I-I төвийн үйл ажиллагааг зогсоож хаах шийдвэр гаргаж байсан.<sup>4</sup> Гэвч дараа нь уг төвийг буцаан нээж, иргэдийн санал хүсэлтийг үргэлжлүүлэн хүлээн авсан. Иргэдээс ирсэн санал хүсэлтийг <http://www.I-I-I.mn/> цахим хуудсанд бичгээр болон аудио файлаар байршуулдаг. Хэдийгээр үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа ч засгийн газрын зүгээс энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх алжын чиглэлээр ямар нэг шинэ алхам хийгээгүй.

Засгийн газар 11-11 төвийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй (1.1), 11-11 төвийн аппликашныг ашиглах заавар гаргаагүй (1.7), аппликашн сервисийн үйл ажиллагааны хөндлөнгийн үнэлгээг хийлгээгүй (1.9). Гар утасны аппликашн уг зорилтоос өмнөх цаг хугацаанд гарсан байна. (1.2-1.5) Аппликашн 2015 оноос хойш шинэчлэгдээгүй байна.<sup>5</sup> (1.7, 1.8)

Гэвч засгийн газрын үйл ажиллагаанаас үл хамааран иргэний нийгмийн зүгээс энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулав. Ардчиллын боловсрол төв (ДЕМО)ТББ Нийслэл Улаанбаатар хот дахь төрийн үйлчилгээний талаар гар утасны аппликашн хөгжүүлэх санаачлага гаргасан. Иргэний нийгмийнхний судалж тогтоосноор 11-11 төвд ирж буй санал хүсэлтийн 80% нь<sup>6</sup> Улаанбаатар хотоос ирж байна.

ДЕМО ТББ уг төслөө Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газарт (ЗДТГ) таницуулсан хамтран ажиллахаар тохирч, Австралийн Засгийн газрын Шууд тусlamжийн хөтөлбөрөөс санхүүжилт авсан болно. Үүний үр дүн Check my service аппликашнийг хөгжүүлж, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн өргөдөл гомдол хүлээн авах сервертэй холбуулсан.<sup>7</sup> Улмаар 2018 оны 1-р сарын 31-нд Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн Төвд аппликашний нээлтийг хийсэн ба үүнд хотын удирдлага, олон улсын байгууллага, хувийн хэвшли, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийг төлөөлсөн 100 орчим хүн оролцсон.<sup>8</sup>

2018 оны эхний хагаст ДЕМО Check my service аппликашнийг танилцуулсан богино хэмжээний видео болон сурталчилгааны материалыг телевизийн сувгууд, нийгмийн сүлжээгээр<sup>9</sup> цацаж, олон нийтийн газруудаар тараасан болно. Мөн Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн Төвөөр дамжин ирсэн санал, гомдлын сар тутмын тайланг гаргах замаар мониторинг хийж байна. ДЕМО уг аппликашнийг хэрхэн ашиглах, санал хүсэлтийн мөрөөр төр, засгийн зүгээс авч байгаа арга хэмжээг хянах талаар хэрэглэгчдэд зориулсан зааварчилгаа гаргасан. Аппликашнд ирсэн санал хүсэлтэнд төр, засгийн зүгээс хариулсан байдлаар нь шинэ, судалж байгаа, шийдсэн гэж ангилсан байна.

Нийслэлийн ЗДТГ-ын зүгээс ирсэн санал хүсэлтийг холбогдох төрийн байгууллагуудад илгээж зохих арга хэмжээ авахыг мэдэгдэж байна. Хэдийгээр энэ ажлыг төр, засгийн зүгээс хэрэгжүүлээгүй ч аппликашнийг нийслэлийн засаг захирагааны дэмжлэгтэйгээр боловсруулж нэвтрүүлсэн тул 1.2-т заасан ажлыг тодорхой хэмжээгээр хийж гүйцэтгэсэн гэж үзэж байна.

### **Засгийг нээлттэй болгосон уу?**

**Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг**

**Иргэний оролцоо: Бага зэрэг**

**Төрийн хариуцлагатай байдал: Бага зэрэг**

Check my service ажиллаж эхэлсэн эхний жилдээ иргэдээс 1000 орчим санал, гомдол хүлээн авсан байна. Холбогдох төрийн байгууллагууд эдгээр санал, гомдолд хариулах үүрэгтэй ба хэрхэн шийдсэн талаараа тодорхой мэдээллийг тавих ёстой.

Хэдийгээр 11-11 гар утасны аппликашн ажиллахгүй байгаа боловч Check my service аппликашн иргэдэд өөрсдийн гаргасан санал, гомдолдоо төрийн байгууллагуудаас хариу авах боломжийг бүрдүүлж байна. 2018 оны 1-р сараас 2019 оны 1-р сарын хооронд гарсан санал, гомдлын 60-70% нь холбогдох төрийн байгууллагуудаар шийдэгдсэн байна.<sup>10</sup> Тийм учраас төрийн хариуцлагатай байдал бага зэрэг сайжирсан гэж дүгнэж байна.

### **Дараагийн YAYT-нд орсон уу?**

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р YAYT-нд үргэлжлэн ороогүй.

---

<sup>1</sup> <https://itunes.apple.com/us/app/ii-ii-t-v/id579541331?ls=1&mt=8>

<sup>2</sup> ХБТМ [www.ii-ii.mn](http://www.ii-ii.mn) цахим хуудасны одоогийн хувилбарыг 2016 оны 9-р сар (<https://bit.ly/2jHNgye>) болон 2017 оны 6-р сарын (<https://bit.ly/2K3GloP>) хувилбартай харьцуулсан.

<sup>3</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>4</sup> “II-II төв”-ийг татан буулгана. <http://www.control.mn/i/4460#.XBtTmPZujPZ>

<sup>5</sup> <https://itunes.apple.com/us/app/ii-ii-t-v/id579541331?ls=1&mt=8>

<sup>6</sup> 2 дахь YAYT-ний хэрэгжилтэнд хийсэн иргэний нийгмийн мониторингийн тайлан

<sup>7</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2001/01/OGP\\_Awards-Booklet\\_2016\\_ENG.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2001/01/OGP_Awards-Booklet_2016_ENG.pdf)

<sup>8</sup> <http://eagle.mn/r/40168>

<sup>9</sup> [www.facebook.com/CheckMyService](http://www.facebook.com/CheckMyService)

<sup>10</sup> [www.facebook.com/CheckMyService](http://www.facebook.com/CheckMyService)

## ★ 2. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

### Зорилт:

Хоёр салбарын үйлчилгээний тухай мэдээллийн агуулгыг сайжруулж, түгээх сувгуудыг нэмэгдүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон иргэдийн хоофондох харилцан ойлголцол, хүндэтгэл бүхий харилцаа мөн үр дүнтэй түншлэлийн санаачлагуудыг хэрэгжүүлнэ.

### Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:

Боловсрол болон эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийн хувьд сүүлийн жилүүдэг сайжирч байгаа боловч нийт системийн хувьд нөөц, эх үүсвэрүүдийн дутмаг байдал нь эдгээр салбаруудын дофвитой хөгжилд бэрхшээл учруулсаар байна. Иймд санхүүгийн ихээхэн нэмэлт эх үүсвэрийн шаафдлагагүйгээр төрөөс олон нийтэд үзүүлэх үндсэн гол үйлчилгээнүүд болох боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, мөн олон нийт ялангуяа орлого багатай, эрсдэл бүхий болон аливаа зорилтот бүлгүүдэг үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад ихээхэн анхаарах шаафдлага, хэрэгцээ их байна. Нийгмийн эгэх хариуцлага буюу үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон үйлчилгээ хүлээн авагч иргэдийн хоофон дох бүтээлч, үр дүнтэй харилцаа болон түншлэл нь энэхүү шаафдлагыг хангах нэг боломжит арга зам юм.

### Хэрэгжүүлэх ажлууд:

- 2.1. Орон нутгийн бодлогын баримт бичгүүдэг боловсрол болон эрүүл мэндийн салбарын нэн тэргүүний асуудлуудыг тусгана.
- 2.2. Дэлхийн Банкны НЭХБ төсөл хэрэгжиж буй аймгууд, дүүргүүдэдэг боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад талуудын оролцоо, харилцан түншлэлийн санаачлагуудыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Дэлхийн Банкны НЭХБ төсөл хэрэгжих аймгууд, дүүргүүдээс сонгон авч, тэдгээрт боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дотоод болон гадааг мэдээллийн сүлжээг сайжруулж, хэрэглэгч болон үйлчилгээ нийлүүлэгч талуудын харилцан эргэх холбоо, улмаар харилцан хүлээх хариуцлагыг сайжруулах.

### Хэрэгжүүлэгч байгууллага:

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Сонгогдсон аймгууд болон аүүргүүдийн засаг даргын нийгмийн хөгжлийн хэлтэсүүд, мөн боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, Нийгмийн хариуцлагын төлөөх төвийн болон орон нутгийн ТББ-үүд, Дэлхийн Банкны хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх” (МУНЭХБ) Төсөл

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал	Боломжит үр нөлөө		Хэрэгж сэн байдал	Дуна хугацаа Эцсийн хугацаа	Засгийг нээлттэй болгосон уу?
	Үгүй	Бага	Дуна	Их		Үгүй	Бага	Дуна	Томоохон	
Зорилт					Мэдээллийн хүртээмж Иргээгийн оролцоо Төрийн хариуцлагатай Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн					Муусан Өөрчилгээгүй Бага зэрэг Томоохон Додвийтой
2. Ерөнхий дүн	✓				✓ ✓ ✓			✓	✓	

## Зорилго

Орон нутгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний тухай 1) мэдээллийн агуулга, түгээх сувгуудыг сайжруулна, 2) оролцогч талуудын тэргүүлэх чиглэлийг тусгана, 3) хэрэглэгч болон үйлчилгээ нийлүүлэгч талуудын харилцан эргэх холбоо, харилцан хүлээх хариуцлагыг сайжруулна. Энэхүү зорилт нь Дэлхийн Банк болон Швейцарийн Хөгжлийн Байгууллагын хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх” (МУНЭХБ) төсөлийн хүрээнд хэрэгжинэ.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Ихэнх нь

Дэлхийн банк болон Швейцарийн хөгжлийн агентлагаас төслийн болон нийгмийн эгэх хариуцлагын санаачлагуудын талаар мэдээлэл агуулсан [www.irgen-tur.mn](http://www.irgen-tur.mn) цахим хуудсыг нээсэн болно.! Төсөлд хамрагдагч аймаг бүрт зохион байгуулсан чадавхийг бэхжүүлэх сургалтын үеэр дэд төслүүдийг боловсруулан гаргасан болно. Ерөнхийдөө дэд төслүүд нь боловсрол болон эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар санал хүсэлт хүлээн авахад чиглэж байв. (2.3)

Дэлхийн банкны хөндлөнгийн үнэлгээний тайланда дурьдсанаар 10 дэд төсөл бүгд 2017 оны 9-р сард хэрэгжиж дууссан байна. Эдгээрээс Ховд аймгийн олон нийтийн оролцоот сургууль, Сэлэнгэ аймгийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах дэд төслүүд онцгой сайн хэрэгжиж үр дүн,туршлагыг нь өргөжүүлэн хэрэгжүүлэх боломжтой байна. Төслийн 2017 оны тайланда дурдсанаар Дэлхийн банк, Нийслэлийн ЗДТГ-ын хооронд 2017 оны 3-р сарын 27-нд ядуурлын түвшин өндөртэй Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор дэд төслүүд хэрэгжүүлэхээр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зуржээ.<sup>2</sup> Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны хараат бус явцын тайлангаас үзэж болно.<sup>3</sup>

### Эцсийн хугацаа: Бүрэн хэрэгжсэн

ҮАҮТ-ний 2 дахь жилийн хэрэгжилтийн хугацаанд МУНЭХБ төслийн хүрсэн гол үр дүнг дурьдавал:

- Хот, хөдөөгийн ядуу болон эмзэг давхаргын бүлгүүдэд чиглэсэн нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжүүлэх ИНБ-уудын арга зүй, зохион байгуулалтын чадвар сайжирсан

- Иргэний нийгмийн сүлжээ баримтанд тулгуурласан нөлөөллийн арга хэмжээ болон нийгмийн эгэх хариуцлагын бусад арга хэрэгслийг илүү үр дүнтэй хэрэгжүүлдэг болсон. Жишээ нь 4 ТББ байгууллагын хийсэн хөндлөнгийн үнэлгээ нь Улаанбаатар хотын ЗДТГ-ын эрүүл мэнд, боловсролын салбарын бодлогын хэрэгжилтийн чиглэлээр гаргасан шийдвэрт тусгалаа олсон. Орон нутгийн 2 ТББ иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн Булган, Дархан-Уул аймаг дахь бодлогын хэрэгжилтэд бие даасан үнэлгээ хийсэн. Эдгээр ТББ-үүд энэ үнэлгээ нь МУНЭХБ төслийн арга зүй болон дадлагажуулах дэмжлэгийн үр дүнч хийгдсэн болохыг тайландаа дурьджаа. Аймгийн удирдлагууд судалгааны үр дүнч эерэгээр хүлээн авсан болно. (2.2)
- Нийгмийн эгэх хариуцлагын оролцогч талуудын зүгээс ядуу болон эмзэг давхаргын бүлгүүдийг хамруулах хөшүүргийн тогтолцоо бий болсон. (2.2)
- Төрийн байгууллагуудын зүгээс үйлчилгээний чанараа дээшлүүлэхийн тулд ИНБ болон иргэдээс ирсэн санал гомдолыг хянан хэрэгжүүлэх чадвар сайжирсан. (2.3)
- ИНБ-үүд болон орон нутгийн засаг захиргааны хооронд төрийн нөөцийн удирдлагын асуудалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтарсан асуудал шийдвэрлэх хэд хэдэн ажил албан ёсны боллоо. (2.1) Жишээ нь Говь-Алтай аймагт орон нутгийн боловсролын салбарт иргэдийн оролцоо, нийгмийн эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх “Сайн сургууль” загварыг хэрэгжүүлсэн. Энэ дэд төслийн хүрээнд Алтай Швейцарь ТББ тэргүүтэй орон нутгийн ИНБ-үүд аймгийн төвийн 2, сумдын 2, нийт 4 сургуулийн төсөвт мониторинг хийсэн. Энэхүү мониторингийн мөрөөр орон нутгийн ИНБ-үүд аймгийн ЗДТГ, Боловсролын хэлтэстэй хамтарч сургуулиудын төсөв, хүний нөөцийн асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулсан. Энэ нь 2015 онд Нийтийн сонсголын хууль батлагдсанаас хойш орон нутгийн төсвийн ил тод байдлын чиглэлээр зохион байгуулагдсан анхны нийтийн сонсгол болсон юм.<sup>4</sup>
- Холбогдох төрийн яам, агентлагууд, үйлчилгээний байгууллагууд 2 салбарын талаар гаргасан шийдвэрүүдээ ил тод болгож байна. (2.3)
- Төр, засгийн байгууллагууд, ИНБ-үүд үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал, тогтвортой байдлын чиглэлээр авсан сургамжаа танилцуулсан байна. (2.3)<sup>5</sup>

ЗГХЭГ-ийн хүсэлтээр МУНЭХБ төсөл 21 аймгийн 200 орчим төрийн албан хаагчид, иргэний нийгмийн төлөөлөлд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны аргачалалын талаар онлайн сургалтыг зохион байгуулсан. 2018 оны эхний улиралд аргачалыг хэрэглэсэн байдал, туршлагын талаар дүгнэсэн. Эдгээр чадавхийг бэхжүүлэх арга хэмжээний дараа МУНЭХБ төсөл Дорнод аймаг болон Улаанбаатар хотын 175 төрийн албан хаагчдад (58% нь эмэгтэй) зориулан сургалт зохион байгуулж оролцооны мониторингийн арга, иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг ашиглах чиглэлээр мэдлэгийг нь дээшлүүлсэн.<sup>6</sup>

Нийслэлийн Боловсролын газар болон дүүргүүдийн боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд, нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирлууд болон иргэний нийгмийн байгууллагуудын 140 гаруй төлөөлөл 2018 оны 6-р сарын 11-нд цуглан сургуулийн орчин, сурагчдын хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах зэрэг ерөнхий боловсролын сургуулийг тойрсон асуудлуудын талаар хийсэн хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, сайжруулах зөвлөмжүүдийг хэлэлцээ. Үнэлгээг МУНЭХБ төслийн хүрээнд анх удаагаа ИНБ-үүд хийж гүйцэтгэсэн болно.<sup>7</sup>

МУНЭХБ төслийн зарим дэд төслүүд иргэдийн шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг сайжруулсан болно. (2.2) Жишээ нь 2018 онд Увс аймагт эм болон эмнэлгийн багаж хэрэгслийн худалдан авах үйл ажиллагааны оролцоог хангасан төлөвлөлт, мониторингийн загвар үргэлжлэн хэрэгжсэн байна. Орон нутгийн иргэний нийгмийн сүлжээ болон аймгийн Эрүүл мэндийн газар хамтран ил тод худалдан авалтын ажиллагааг хэрэгжүүлснээр 2018 онд орон нутгийн төсөвт 55 сая төгрөгийн хэмнэлт гарчээ. Эрүүл мэндийн салбарын ажилтанууд, иргэдийн үзэж байгаагаар эм, эмнэлгийн багаж хэрэгслийн чанар сайжирсан байна.

2018 онд Дорнод аймгийн иргэний нийгмийн сүлжээ аймгийнхаа ЗДТГ, Эрүүл мэндийн газартай хамтран үйлчилгээг сайжруулах ажлын төлөвлөгөөг үргэлжлүүлэн боловсруулав. Аймгийн нэгдсэн эмнэлэгт урологийн багаж, хэрэгсэл худалдан авах санал орон нутгийн төсөвт тусгагдахаар хүлээгдэж байна. Мөн ИНБ-уудын бодлогын нөлөөллийн арга хэмжээний үр дүнэ нийтийн эрүүл мэндийн кампанит ажил болон бэлгийн замын халдварт өвчнийг оношлоход 50 сая төгрөгийн санхүүжилт олгогдоо болсон.

Говьсүмбэр аймагт хэрэгжсэн дэд төсөл ЭМЯ-наас гаргасан Ёс зүйн хорооны журмыг хэрэгжүүлэх замаар төрийн байгууллагын хариуцлагатай байдлыг олон нийтийн зүгээс шаардан хангуулах боломжийг бүрдүүлсэн. Орон нутгийн ёс зүйн хорооны ажлын үр дүнэ эрүүл мэндийн салбарын ажилтанууд болон иргэдэд зан үйлийн өөрчлөлт гарсан болно. Төслийн тайланд аурьдсанаар төсөв хангалтгүй, эмнэлгийн удирдлагын зүгээс дэмжлэг аваагүй ч 85% нь залуу сайн аурынхнаас бүрдсэн хороо иргэдээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэж, эмнэлгийн ажилтнуудын дунд хэрэглэгчдэд хандсан үйлчилгээг сурталчлан таниулсан байна. Мөн Ёс зүйн хороо ажилтнуудын хоорондын зөрчлийг багасгажээ. Энэхүү ажлыг ЭМЯ-ны зүгээс эрүүл мэндийн салбарын удирдлагын шилдэг арга барилын нэгээр шалгаруулсан байна.<sup>8</sup>

Засгийг нээлттэй болгосон уу?

Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг

Иргэний оролцоо: Томоохон

Төрийн хариуцлагатай байдал: Бага зэрэг

Энэхүү зорилтын хүрээнд худалдан авалтын мэдээлэл ил тод байдал болсон зэргээр мэдээллийн нээлттэй байдал бага зэрэг сайжирсан байна. Дорнод аймагт эмнэлгийн хүртээмж дутмаг байгаа, эрчүүдийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчний талаар олон нийтэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл хүргэжээ. Мөн иргэдийн санал хүсэлтийн дагуу аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газраас ИНБ-уудтай хамтран 1000 гаруй хүнд нийтийн эрүүл мэндийн талаар танилцуулга хийсэн байна.<sup>9</sup>

МУНЭХБ төслийн үр дүнэ орон нутагт нийгмийн эгэх хариуцлагын чадавхийг бүрдүүлснээр иргэний оролцоо дорвitoй сайжирчээ. Тайланд дурьдсанаар зарим аймагт шийдвэр гаргах, асуудлыг шийдэх үйл явцад ИНБ-үүд болон иргэдийг оролцуулах зайлшгүй оролцох хэрэгтэй гэж үздэг болсон байна. БСШУЯ иргэдийн оролцоог ханган боловсролын үйлчилгээг сайжруулах салбарын онцлогтой бодлого боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Энэ нь Дорнод аймаг дахь оролцоог хангасан сургуулийн загварын туршлага дээр үндэслэсэн байна. Мөн төр, засгийн зүгээс жендерийн дэд хөтөлбөрийг боловсруулах, зөвлөлдөх үйл явцад орон нутгийн ИНБ-уудыг урин оролцуулжээ.<sup>10</sup>

Эрүүл мэндийн байгууллагуудад Ёс зүйн хороо байгуулсан, төрийн байгууллагуудаас иргэдийн санал хүсэлтэнд хариу өгөх чадавхийг сайжруулсан зэрэг нь төрийн хариуцлагатай байдлыг бага зэрэг сайжруулах боломжийг бүрдүүлсэн байна. Гэвч энэ нь төр, засгийг гаргасан шийдвэртээ бүрэн хариуцлага хүлээдэг тодорхой механизм болж чадаагүй байна.

## Дараагийн YAYT-нд орсон уу?

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р YAYT-нд үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> <http://www.irgen-tur.mn>

<sup>2</sup> МУНЭХБ төслийн 2017 оны ажлын тайлан. 2017.09.17

<sup>3</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>4</sup> <http://www.irgen-tur.mn/en/social-accountability-initiative-gobi-altai-aimag>

- 
- <sup>5</sup> МУНЭХБ төслийн 2018 оны ажлын тайлан. Хамарсан хугацаа: 2017.09.01-2018.07.31
- <sup>6</sup> МУНЭХБ төслийн 2018 оны ажлын тайлан. Хамарсан хугацаа: 2017.09.01-2018.07.31
- <sup>7</sup> <http://www.irgen-tur.mn/mn/боловсролын-бодлогын-хэрэгжилтэд-хийсэн-хөндлөнгийн-үнэлгээний-ур-дүнг-иргэний-нийгмийн>
- <sup>8</sup> МУНЭХБ төслийн 2018 оны ажлын тайлан. Хамарсан хугацаа: 2017.09.01-2018.07.31
- <sup>9</sup> МУНЭХБ төслийн 2018 оны ажлын тайлан. Хамарсан хугацаа: 2017.09.01-2018.07.31
- <sup>10</sup> МУНЭХБ төслийн 2018 оны ажлын тайлан. Хамарсан хугацаа: 2017.09.01-2018.07.31

### **3. Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо**

#### **Зорилт:**

Төрийн бодлого, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн хуулиудаг<sup>1</sup> тусгагдсан иргэдийн оролцооны эрхийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, иргэд эрх, үүргээ бодитойгоор хэрэгжүүлэх замаар олон нийтийн эрх ашигийг хөндсөн шийдвэр гаргах ажиллагаанд идэвхтэй оролцож шударага ёсыг бэхжүүлэх.

#### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Төрийн бодлого, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захирагааны ефөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хуулиуг батлагдсан. Эдгээр хуулиудын хэрэгжилтэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байна.

#### **Хэрэгжүүлэх ажлууд:**

3.1. Иргэн-олон нийтийн хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй захирагааны шийдвэр гаргах үйл явцад иргэд хэрхэн тайлбар, санал гаргах талаарх сургалт, сурталчилгааг өргөн хүрээнд явуулах

3.2. Төрийн захирагааны байгууллага, засаг дафга наф нийтийн эрх ашиг хөндөгдөж болзошгүй асуудлаарх шийдвэрийн төслөө олон нийтэд танилцуулж, санал өгөх хангалттай хугацаанг ил тог, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх

3.3. Төрийн захирагааны байгууллага, засаг дафга наф нийтийн эрх ашиг хөндөгдсөн шийдвэрт иргэдийн оролцоог хангасан байдалг үнэлгээ хийх

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Бүх шатны төрийн захирагааны байгууллагууд, Нээлттэй нийгэм форум, МҮОНРТ- “Монголын мэдээ” суваг, Хяналт үнэлгээ мониторинг болон бодлогын чиглэлээр ажилладаг ТББ-үүд, Монголын Сэтгүүлчдийн Эвлэл, “Глоб интернэшнл” ТББ

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал			Боломжит үр нөлөө		Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?							
	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчилэл	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвигий
Зорилт	Үгүй	Бага	Дуна	Их	✓	✓			✓	✓			✓	✓			✓	✓			
3. Ерөнхий АҮН	✓				✓	✓												✓			

## Зорилго

Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангаснаар олон нийтийн эрх ашигт зэрэг нөлөө үзүүлэх. Мөн зорилтын хүрээнд захиргааны шийдвэр гаргах үйл явцад иргэд хэрхэн тайлбар, санал гаргах талаарх сургалт, сурталчилгааг өргөн хүрээнд явуулах, шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулж, санал өгөх хангалттай хугацаанд ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, шийдвэрт иргэдийн оролцоог хангасан байдалд үнэлгээ хийх зэрэг ажлууд орсон болно.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Хэрэгжиж эхлээгүй

Дунд хугацаанд энэхүү зорилт хэрэгжиж эхлээгүй. 2017 оны 6-р сараас 9-р сарын хооронд УИХ улс орон даяар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар хэлэлцүүлгийг нийт орон даяар явуулсан.<sup>2</sup> Гэвч хэлэлцүүлэг нь энэ зорилттой холбоотой эсэх нь тодорхойгүй байна.

### Эцсийн хугацаа: Дутуу

ҮАҮТ хэрэгжсэн 2 дахь жилд зарим төрийн яамд болон төрийн бус байгууллагууд уулзарт, зөвлөгөөн зохион байгуулсан. 2016-2017 онд Хууль зүйн яам, Ханс Зайделийн Сангийн хамтран зохион байгуулсан Захиргааны ерөнхий хуулийг танилцуулах сургалтуудад 3000 төрийн албан хаагчид оролцов. (3.1) Нээлттэй Нийгэм Форум (ННФ) аймгуудад болон Улаанбаатар хотод иргэдэд зориулан Захиргааны ерөнхий хууль болон Нийтийн сонсголын хуулийн талаар сургалт зохион байгуулсан. Сургалтандаа 16 аймаг, Улаанбаатар хотыг төлөөлсөн 70 ТББ-ын 100 гаруй хүн оролцсон.<sup>3</sup>

Мөн ННФ-ийн зүгээс Нийтийн сонсголын хуулийн талаар танилцуулга бэлтгэж түгээсэн.<sup>4</sup> Энэхүү 4 хуудас танилцуулгад хууль, тогтоомж, сонсгол явуулах нөхцөл, үйл явц, дараалал, оролцогчийн эрх, үүрэг зэрэг мэдээллийг оруулсан байна. Гэвч ҮАҮТ-ний хэрэгжилтийн хугацаанд төрийн дээд шатны байгууллагуудын зүгээс нийтийн сонсгол зохион байгуулаагүй. Хамгийн эхний нийтийн сонсголыг УИХ 2019 оны I-р сарын 30-нд буюу энэхүү ҮАҮТ-ний хэрэгжилтийн хугацаа дууссаны дараа зохион байгуулсан.

ННФ-с 2017 оны 8-р сард Нийтийн сонсголын тэтгэлэгт хөтөлбөрийг эхлүүлсэн. Энэхүү хөтөлбөрт нийт 8 байгуулага хамрагдсанаас 7 нь орон нутгийн хөгжлийн сан, газар зохион байгуулалт, байгаль орчны мониторинг зэрэг өөр өөрсдийн сонгосон чиглэлээр орон нутагт нийтийн сонсгол зохион байгуулсан. Эдгээрт нийт 524 иргэн оролцсон болно.<sup>5</sup> Утааны эсрэг ээж аавууд ТББ Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудлаар сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасан боловч Ерөнхийлөгчийн тамгын газар, УИХ, Байгаль орчны яам зэрэг байгууллагаас дэмжлэг авч чадаагүй. <sup>6</sup> 2018 оны 3-р сард тэтгэлэг авсан 8 байгуулага хоорондоо уулзаж туршлага солицсон болно.

### **Засгийг нээлттэй болгосон уу?**

#### **Мэдээллийн хүртээмжк: Өөрчлөгдөөгүй Иргэдийн оролцоо: Өөрчлөгдөөгүй**

Энэхүү зорилт нь олон нийтийн эрх ашигт тустай шийдвэр гаргахад хүргэж хүртээмжтэй хэлбэрээр олон нийтэд хүрээгүй байгаа тул мэдээлийн хүртээмжийг өөрчлөгдөөгүй гэж дүгнэж байна.

Шинэ хуулиудын танилцуулах сургалтуудыг төрийн байгууллагууд болон иргэний нийгмийн зүгээс зохион байгуулсан. Мөн ННФ нийтийн сонсголд тэтгэлэг олгож, танилцуулах материал түгээсэн. Эдгээр үйл ажиллагаа нь иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын дунд хуулийн тухай ойлголтыг ямар нэг хэмжээгээр нэмэгдүүлсэн ч, төрөөс гаргах аливаа шийдвэрт нөлөөлөх олон нийтийн чадавхийг нэмэгдүүлсэн гэсэн баталгаа болохгүй.<sup>7</sup>

### **Дараагийн YAYT-нд орсон уу?**

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р YAYT-нд үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль.

<sup>2</sup> “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийгмийн сүлжээгээр санал өгч болно”, МОНЦАМЭ, 2017 оны 6-р сарын 5, <https://www.montsame.mn/mn/read/56546>

<sup>3</sup> Нээлттэй Нийгэм Форум. Жилийн тайлан 2017.

<sup>4</sup> [http://forum.mn/res\\_mat/2017/NNF.pdf](http://forum.mn/res_mat/2017/NNF.pdf)

<sup>5</sup> Нээлттэй Нийгэм Форум. Жилийн тайлан 2017

<sup>6</sup> <http://eagle.mn/r/42408>

<sup>7</sup> Нээлттэй Нийгэм Форум. Жилийн тайлан 2017

## **4. Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх**

### **Зорилт:**

Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлуулах, энэ хүрээнд улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох асуудлыг хуульд тусган зохицуулах.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Улс төрийн намуудын санхүүжилтийн асуудал зөвхөн Монгол Улсад төдийгүй олон улсын түвшинг ч анхаарал татсан сэдэв болоог байна. Дотоодын олон тооны судалгааны тайлан, баримт бичгүүдээд улс төрийн намууд хамгийн авлигаг өртөн болон өртөх эфсдэлтэй институцид тооцогдож байгаа ба сонгуулийн санхүүжилттэй холбоотой гараж зөрчлийг нэмэгдсээр байгаа нь энэ талаарх зохицуулалт иж бүрэн, төгс болоогүйг харуулж байгаа юм. Энэ байдал нь улс төрийн үйл явцыг гажууруулж, улс төрийн намын төлөвшийг сөргөөр нөлөөлж, сонгууль шударга бус явагдахад хүргэж, нөгөө талаасаа авлига бий болох хөрс суурь болдог нь олон улсын түршлагаас тодорхой байна. Иймд улс төрийн намуудын санхүүжилтийн асуудлыг нарийвчлан зохицуулах, ил тод, нээлттэй, хяналттай, хариуцлагатай болгох шаардлага зайлшгүй тулгамдаж байгаа болно.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

4.1. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, “Нийтийн сонголын тухай” хуулиудад тус тус заасан процессиийн дагуу арга хэмжээ төлөвлөх, НЗТ-ийн талуудыг оролцуулах.

4.2. Хуулийн төсөлд улс төрийн намуудын санхүүжилтийн асуудлыг нарийвчлан тусгах, үүнд ил тод, хариуцлагатай байдлыг хэрхэн хангах талаар тодорхой заах хуулийг УИХ-аар батлуулах ажлыг зохион байгуулах.

4.3. Хуулийн төслийг батлах хүртэл НЗТ-ийн талуудтай хамтран нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Үндэсний Аудитын газар, Татварын Ерөнхий Газар, Авлигатай Тэмцэх Газар, Төрийн ил тод байдал, авлига, засаглалын асуудлаар судалгаа шинжилгээ хийн идэвхтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд, МҮОНРТ, МҮХАЯТанхим, улс төрийн намууд

**Хэрэгжүүлж эхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал			Боломжит үр нөлөө		Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?							
	Үгүй	Бага	ДундA	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчилэл	Үгүй	Бага	ДундA	Томоохон	Эхээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвигий
Зорилт																					
4. Ерөнхий АҮН		✓			✓	✓				✓				✓	✓				✓		

## Зорилго

Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлуулах, энэ хүрээнд улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох асуудлыг хуульд тусган зохицуулах, хуулийн төслийг батлах хүртэл Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад тус тус заасан процесийн дагуу НЭТ-ийн талуудтай хамтран нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Дутуу

ҮАҮТ-ний хэрэгжилтийн эхний жилд 2016 оны 6-р сард болсон сонгуулийн дараа бүрэлдсэн УИХ нийтийн сонсгол зохион байгуулаагүй, мөн Улс төрийн намын тухай хуулийн төслийг боловсруулаагүй. (4.1, 4.2) Харин эрдэмтэн, судлаачид болон УИХ-ын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн дэд ажлын хэсэг байгуулагдаж хуулийн төслийг боловсруулах ерөнхий төлөвлөгөөг гаргасан. Тийм учраас дунд хугацаанд зорилтыг дутуу хэрэгжсэн гэж үзлээ.

Илүү дэлгэрэнгүйг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>1</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

УИХ 2017 оны 12-р сард Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.<sup>2</sup> Ажлын хэсэгт УИХ-д судалтай бүх намын төлөөлөл орсон. Мөн улс төр судалаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачид, УИХ-ын Тамгын газрын ажилтануудаас бүрдсэн дэд ажлын хэсгийг байгуулсан. Гэвч ҮАҮТ хэрэгжиж дуусах хугацаанд Улс төрийн намын тухай хуулийн төсөл гараагүй бөгөөд төр, засгийн байгууллагуудын зүгээс хэлэлцүүлэг болон нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй. (4.1, 4.2, 4.3)<sup>3</sup> Хууль зүй, дотоод яамны мэдээлсэнээр хуулийн төслийг боловсруулах ажил нь УИХ-ын ажлын чиг үүрэгт хамаарна.

Гэхдээ иргэний нийгмийн зүгээс хуулийг төслийг батлуулах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. 2018 оны 4-р сарын 19-нд Транспэрэнси Интернейшил Монгол байгууллага УИХ-ын гишүүд, иргэний нийгэм, судлаачдыг оролцуулсан “Улс төрийн намын санхүүжилт ба өндөр

түвшний авилгаас сэргийлэх нь” сэдэвт уулзалтыг зохион байгуулав. Энэхүү уулзалтаар “шүгэл үлээгчдийг” хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээ, улс төрийн намуудын авилгад өртөх байдлыг индексжүүлэх зэрэг асуудлыг авч хэлэлцсэн.<sup>4</sup>

ННФ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнтэй хамтран 2 жилийн хугацаатай “Улс төрийн санхүүжилт: Ёс зүй, хариуцлага, оролцоо” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд улс төрийн санхүүжилтийн талаар уулзалт, хэлэлцүүлгүүдийг эмэгтэйчүд, залуус зэрэг төрөл бүрийн оролцогч талуудыг хамруулан зохион байгуулсан.<sup>5</sup>

## Засгийг нээлттэй болгосон уу?

### Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй Иргэдийн оролцоо: Бага зэрэг

Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулсан Улс төрийн намуудын хууль батлагдаагүй, нөлөөллийн арга хэмжээ төр, засгаас үл хамааран явагдсан учраас мэдээллийн хүртээмж өөрчлөгдөөгүй.

Хуулийн төслийг боловсруулах эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулагдаж, УИХ-ын гишүүд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан ажлын уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулагдсан тул иргэдийн оролцоог бага зэрэг гэж үзлээ.

## Дараагийн YAYT-нд орсон уу?

Энэхүү зорилт нь Монгол улсын З-р YAYT-нд Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн 8-р зорилт болон орсон. Зорилтын хүрээнд Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, хяналт, хариуцлагыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан Улс төрийн намын тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх, хууль сахиулах байгууллагуудын хараа хяналтыг сайжруулах, авилгын боломжит тохиолдоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, улс төрийн намуудын үүрэг, хариуцлагын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, улс төрийн намуудаас хариуцлага нэхэх чадавхийг бий болгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

<sup>1</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>2</sup> ХБТМ болон Нээлттэй Нийгэм Форумын ажилтаны хоорондын имэйл. 2018 оны 5-р сарын 4.

<sup>3</sup> Улс төрийн намуудыг төсвөөс санхүүжүүлэх нь. <http://jargaldefacto.com/article/uls-turiin-namuudiig-ulsii-tuswuus-sankhuujuulekh-ni>. 2017.09.28

<sup>4</sup> Уулзалтын бичлэг: <https://www.facebook.com/TransparencyInternationalMongolia/videos/1651129658339636/>

<sup>5</sup> Нээлттэй Нийгэм Форум. Жилийн тайлан 2017.

## **5. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ**

### **Зорилт:**

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн салбарын ажилчдын өргөн төлөөлөлтэйгөөр хэлэлцүүлэх, агуулаг тавих хязгаафлалтыг дахин авч үзэж сайжруулан батлуулах, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ОНРТ-ийг улс төрийн нөлөөнөөс ангиg, санхүүгийн хувьсг бие даах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2014-2016 оны YAYT-ний хэрэгжилтэд хийсэн Хараат бус тайланг хөндлөнгийн шинжээчийн тусгайлан өгсөн зөвлөмжөөс дөрөвдүгээр зөвлөмжид 2016-2018 оны YAYT-нд хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарынхантай хамтран хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаар зорилт оруулах тухай тусгажээ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд улс төрөөс шууд хяналт тогтоохыг оролдож байгаа нь сэтгэл түгшээж байна. Хэвлэл мэдээллийн тоо өсөн нэмэгдэж, 3 сая хүн амтай зах зээлийг бүрэн хангагд байгаа. Томоохон улс төрчиг болон бизнес эрхлэгчид ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг эзэмших болсон бөгөөд “хамтын ажиллагааны гэрээ” байгуулах болсон бөгөөд эггээр гэрээнд захиалагчийн талаар сөрөг мэдээлэл цацахгүй байх тухай заалт орсон байдаг.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

5.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэх, ингэхдээ олон улсын хэм хэмжээнд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж УИХ-г танилцуулах

5.2. Тус хуулийн олон нийтээр хэлэлцэгдсэн, мэдээллийн эх сурвалжaa хамгаалах сэтгүүлчийн эрхийг тогтоосон, хамгаалсан, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчийн талаар мэдээллийг ил тод болгох заалт бүхий олон улсын хэм хэмжээнд нийцсэн төслийг өргөн барих

5.3. Хуулийг батлуулах хүртэлх нөлөөллийн үйл ажиллагааг НЗТ-ийн талуудын оролцоотой төлөвлөж, хариуцан ажиллах

5.4. Олон нийтийн радио телевизийн тухай хуульд “... улс төрийн нөлөөнөөс ангиg, санхүүгийн хувьсг бие даасан...” байх тухай ямар нэмэлт өөрчлөлт байж болох санаалыг мэргэжлийн холбоогоос авч, хэлэлцүүлэх

5.5. Хэлэлцэгдэж ойлголцсон нэмэлт өөрчлөлтийг өргөн мэдүүлэх, нэмэлт өөрчлөлтийг хүлээн авталь нөлөөллийн үйл ажиллагааг Хэвлэл мэдээллийн салбартай хамтран зохион байгуулах.

5.6. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчийн талаар мэдээллийг ил тод болгох асуудлыг хуулиар нэг мөр зохицуулж мөрдүүлэх.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, УИХ-ын Тамгын Газар, бусад холбогдох байгууллагууд, Төрийн ил тод байдал, авлига, засаглалын асуудлаар судалгаа шинжилгээ хийн идэвхтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

Хэрэгжүүлж дуусах огноо: 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал				Боломжит үр нөлөө		Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?						
	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай	Ил тоо байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвигий
Зорилт					✓	✓						✓		✓							
5. Ерөнхий дүн			✓		✓	✓								✓					✓		

## Зорилго

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалсан, улс төрийн нөлөөнөөс ангиid, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцлийг хангасан хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах. Мэдээллийн эх сурвалжкаа хамгаалах сэтгүүлчийн эрхийг тогтоох, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчдийн талаар мэдээллийг ил тод болгох. Эдгээр нэмэлт өөрчлөлтийг олон нийт болон мэргэжлийн холбоодыг оролцуулсан хэлэлцүүлгийн үндсэн дээр боловсруулан гаргана.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Дутуу

2016 оны 12-р сард Засгийн газар УИХ-д Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг өргөн барьсан.<sup>1</sup> (5.5) Хуулийн зүйл ангиуд нь хэвлэл мэдээллийн эзэмшигчдийн мэдээллийг ил тод болгох ерөнхий зорилгыг хангасан байна. Гэвч Харилцаа холбооны зохицуулах хороог бие даасан байгууллага болгоогүй, орон нутгийн нэвтрүүлэгч байгууллагуудыг орхигдуулсан, нэвтрүүлгийн агуулгад хатуу хяналт тогтоох зэргээр олон улсын стандарттай нийцэхгүй хэд хэдэн асуудал байна.<sup>2</sup> Мөн тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг үнэлэх шалгуур тодорхойгүй, тусгай зөвшөөрөл олгох үйл явц ил тод бус, олон нийтийн оролцоог хангагүй байна.<sup>3</sup> Төр, засгийн холбогдох байгууллагуудын зүгээс олон нийт болон мэргэжлийн холбоодыг оролцуулсан хэлэлцүүлэг болон нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй. (5.4, 5.5)

2017 оны 3-р сард телевизийн төлөөлүүд МҮОНТ-ээр явагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэлэлцүүлэгт оролцсон.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>4</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль өргөн баригдсан боловч олон нийт, мэргэжлийн холбоодыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулагдаагүй. (5.5) 2018 оны 4-р сарын 24-нд УИХ-ын 6 гишүүн хэвлэл, мэдээллийн төлөөллийг хүлээн авч уулзан хэвлэлийн эрх чөлөөг хангах арга замууд, хэвлэл мэдээллийн хууль эрхзүйн орчинг сайжруулах, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиудад ямар өөрчлөлт оруулах талаар санал солилцсон. (5.1, 5.4)

МООНТ-ийн Зөвлөлийн гишүүд улс төрийн ашиг сонирхлын дагуу томилогддог, төсвийг нь засгийн газар баталсан хэвээр байна. Тийм учраас МООНТ улс төрөөс хараат хэвээр байна. ЯАҮТ хэрэгжиж дуусахад Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдаагүй.

ЯАҮТ-ний хэрэгжилтийн 2 дахь жилд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулах, нөлөөллийн үйл ажиллагааг явуулах талаар ямар нэг ахиц гараагүй. (5.1-5.3)

## Засгийг нээлттэй болгосон уу?

Мэдээлийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй  
Иргэдийн оролцоо: Өөрчлөгдөөгүй

Хэдийгээр Өргөн нэвтрүүлгийн тухай хууль УИХ-д өргөн баригдсан ч ЯАҮТ-ний хэрэгжилтийн хугацаанд энэхүү хууль нь батлагдаагүй учраас мэдээллийн хүртээмж өөрчлөгдөөгүй гэж үзэж байна. Мөн төр, засгийн зүгээс хуулийн төслийг боловсруулах талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй учраас иргэдийн оролцоог өөрчлөгдөөгүй гэж үзлээ.

Хэвлэл мэдээлийн байгууллагын эзэд өөрсдөө эдийн засгийн давуу байдал үүсгэх, улс төрийн ашиг сонирхлын үүднээс уг салбарт бизнес эрхэлж байна. Монгол Улсын Хэвлэл мэдээллийн өмчлөлийн мониторингийн (ХМӨМ)<sup>5</sup> судалгаанд 39 мэдээллийн хэрэгслийг хамруулжээ. Судалгааны үр дүнд нийт байгууллагын 74% нь эзэд болон үүсгэн байгууллагчаараа дамжуулан улс төрөөс хамааралтай байна. Монголын нэгээс бусад бүх телевизүүдийг улс төрд нөлөө бүхий хүмүүс эзэмшдэг. Хэвлэл мэдээллийн байгууллагын 89%-ийн эздиин талаарх мэдээлэл ил тод биш. Санхүүгийн бүтэц зохион байгуулалт, эздиин талаарх мэдээлэл нийт байгууллагын бараг 50 хувьд нь тодорхой бус байна.

Одоо мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд гүтгэлэгтэй холбоотой заалтаар хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд өндөр дүнтэй тorgууль оногдуулдаг.<sup>6</sup>

Олон нийт хэвлэл мэдээллийг улс төрийн системийг хянах үүрэгтэй гэхээс илүү тэрхүү системийн нэг хэсэг гэж үзэж байна.

## Дараагийн ЯАҮТ-нд орсон уу?

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р ЯАҮТ-нд үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (төсөл), <http://forum.parliament.mn/projects/356>

<sup>2</sup> Centre for Law and Democracy, Mongolia: Analysis of the Draft Broadcasting Law, March 2017, [https://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2012/08/Mongolia\\_Broadcasting\\_Mar17analysis.pdf](https://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2012/08/Mongolia_Broadcasting_Mar17analysis.pdf), pg. 1.

<sup>3</sup> Өмнөх ишлэлтэй ижил. pg. 6.

<sup>4</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>5</sup> Хил Хязгааргүй Сэтгүүлчид, Монголын Хэвлэлийн Хүрээлэн. Хэвлэл мэдээллийн өмчлөлийн мониторинг. 2016. <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-media/>

<sup>6</sup> Транспэрэнси Интернэшил Монгол. Шударга бизнес Монгол улсын хөтөлбөр 2018. <https://bit.ly/2AyA2zu>

## 6. Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр

### **Зорилт:**

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг (ATYX) хэрэгжүүлэхэд НЗТ-ийн бүх талын оролцоог ханган идэвхтэй ажиллах.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр 2002-2010 онд хэрэгжиж дууссанаас хойш үндэсний хэмжээнд авилгын эсрэг стратеги, хөтөлбөр батлагдаагүй байна. Авилгын эсрэг баримтлах төрийн бодлогыг цогцоор нь тодорхойлох, холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг боловсронгуй болгож, уялдаа холбоог сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

6.1. ATYX батлагдсан тохиолдолд хэрхэн ажиллах төлөвлөлт хийх зорилго бүхий НЗТ-ийн бүх талуудын оролцоог хангасан уулзалт хийх.

6.2. ATYX-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны оролцох, хамтран ажиллах тухай НЗТ-ийн талуудын санаалыг хүргүүлэх.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, болон бусад холбогдох байгууллагууд


**Хамтран ажиллах байгууллага:** Авилгатай тэмцэх газар, бусад холбогдох төрийн байгууллагууд, MYHAYT, Засаглалын ил тод байдлыг хангах чиглэлээр ажилладаг ТББ-үүд МҮОНРТ, “Монголын мэдээ” суваг

**Хэрэгжүүлж эхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал				Боломжит үр нөлөө		Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон үү?							
	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүргтээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тоо байдал, хариуцлагатай байдалыг сайжруулах технологийн шинэчлэвлэл	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Мууссан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвигий	
Зорилт																						
6. Ерөнхий дүн		✓				✓			✓					✓						✓		



## Зорилго

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НЗТ-ийн оролцогч талуудыг хамруулах. 2016 оны I I-р сард УИХ-аас батлан гаргасан авилгын эсрэг стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулах.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Дутуу

2017 оны I-р сард засгийн газар Авилгын эсрэг үндэсний форумыг зохион байгуулж, иргэний нийгмийн байгууллагууд, яамд, агентлагуудаас АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал авсан болно.<sup>1</sup> (6.I) 2017 оны 4-р сард засгийн газар шинэ АТҮХ-ийг 2016-2023 онуудад 2 үе шаттай хэрэгжүүлэх 216 арга хэмжээг багтаасан төлөвлөгөөг боловсруулан гаргасан.<sup>2</sup> Төлөвлөгөөг олон талуудын санал, зөвлөмжийг тусган гаргасан болно.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>3</sup>

### Эцсийн хугацаа: Ихэнх нь

2017 АТҮХ-ийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нийт 499,6 сая төгрөгийг санхүүжүүлсэн.<sup>4</sup> АТГ засгийн газрын харьяа байгууллагуудаас хэрэгжилтийн тайланг нь авч нэгтгэн УИХ-ын байнгын хороонд хүргүүлдэг. Хэрэгжилтийн нэгдсэн тайлан 2018 оны 8-р сард гарсан болно.<sup>5</sup>

6.2-т заасан хэдэн хэдэн санаачлага дээр ахиц дэвшил гарсан байна. 2017 оны 12 дугаар сард Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг батлан гаргаж 10 яам , 14 агентлагт авлигын эрсдэлийн үнэлгээг ТББ-удаар гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулсан. Эдгээр үнэлгээний үндсэн дээр өндөр эрсдэл бүхий уул уурхай, боловсрол, эрүүл мэндийн салбар, гаалийн байгууллага дахь авилгын шалтгааныг тодорхойлох арга хэмжээ авч байна. Энэ нь хэрэгжүүлэх ажил 6.2-той холбоотой. Мөн АТГ авлигаас урьдчилан сэргийлэх , соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх , байгууллагын үйл ажиллагааг сурталчлах , авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий Олон нийтийн төвийг байгуулсан. Уг төв нь иргэд, хувийн хэвшлийнхэнд зориулж 9 удаагийн сургалт зохион байгуулж, үүнд 309 хүн оролцсон болно.<sup>6</sup>

Нийт 21 аймаг, нийслэл хотод Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон яам , агентлагуудын дэргэд Авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг байгуулав.<sup>7</sup> 2017 оны 12 дугаар сард зөвлөлийн гишүүдэд зориулан олон нийтийн хяналтын талаар 3 хоногийн сургалтыг зохион байгуулав. Сургалтанд зөвлөлд ажиллах нийт 152 гишүүнээс 142 нь оролцлоо.

АТГ-ын зүгээс сургалт зохион байгуулах, танилцуулга гаргах, авилгын эсрэг мэдээллийн кампанит ажил явуулах зэрэг чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Эдгээр ажилд Глоб Интернэшнл, ННФ, Транспэрэнси Интернэшнл Монгол болон бусад ТББ-үуд оролцож байна.<sup>8</sup>

### Засгийг нээлттэй болгосон уу?

### Иргэдийн оролцоо: Бага зэрэг

АТҮХ батлагдсан нь иргэний нийгмийн олон жилийн хүчин зүтгэлийн чухал үр дүн болсон юм.<sup>9</sup> Авилгын эсрэг үндэсний форум нь олон талын оролцоотой болж, иргэний нийгмийн зүгээс ирсэн саналуудыг АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан болно. Иргэд болон ИНБ-үүд АТҮХ-ийг хэрэгжүүлэх олон чиглэлийн арга хэмжээнд оролцож, иргэний хяналтын зөвлөлүүд байгуулагдсан болно.

Хэдийгээр эдгээр үйл ажиллагаанд оролцсоноор иргэдийн оролцоо бага зэрэг сайжирсан ч төрийн байгууллагуудад авилгын түвшин өндөр байгаа гэж олон нийт үзсэн<sup>10</sup>, Транспэрэнси Интернэшил байгууллагын 2017 оны Авилгын индексээр<sup>11</sup> Монгол улс 180 улсаас 103-р байрт байгаа нь шаардлагатай хийх ажил их байгааг харуулж байна.

## Дараагийн ҮАҮТ-д орсон уу?

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р ҮАҮТ-д үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлд засгийн газрын гишүүд, зарим байгууллагаас ирүүлсэн санаал: <http://www.iaac.mn/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/ATUH.tusuld.sanal.pdf>

<sup>2</sup> Өмнөх ишлэлтэй ижил.

<sup>3</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>4</sup> АТҮХ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (2017) <http://www.iaac.mn/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/avligatai-temtseh-gazriin2018-medeelel.pdf>

<sup>5</sup> Өмнөх ишлэлтэй ижил.

<sup>6</sup> Өмнөх ишлэлтэй ижил.

<sup>7</sup> OECD. 2019. Anti-Corruption Reforms in Mongolia, Fighting Corruption in Eastern Europe and Central Asia. <https://www.oecd.org/corruption/acn/OECD-ACN-Mongolia-4th-Round-Monitoring-Report-2019-ENG.pdf>

<sup>8</sup> АТҮХ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (2017) <http://www.iaac.mn/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/avligatai-temtseh-gazriin2018-medeelel.pdf>

<sup>9</sup> ННФ-ын менежер Д.Энхцэцэгтэй хийсэн ярилцлага. 2018 оны 9-р сар.

<sup>10</sup> Азийн сан, Сантмарал сан. Авилгын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоо судалгаа 2017, [https://asiafoundation.org/wp-content/uploads/2017/09/MG-SPEAK2017\\_MNG.pdf](https://asiafoundation.org/wp-content/uploads/2017/09/MG-SPEAK2017_MNG.pdf)

<sup>11</sup> Transparency International, Corruption Perceptions Index 2017, [https://www.transparency.org/news/feature/corruption\\_perceptions\\_index\\_2017](https://www.transparency.org/news/feature/corruption_perceptions_index_2017)

## 7. Гадаад зээл, тусlamжийн ил тод байдал

### Зорилт:

Олон улсын байгууллагаас авсан зээл, тусlamж, төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд ил тод болгох ажлыг эрчимжүүлэх.

### Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:

Гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн мэдээлэл иргэд, олон нийтэд хүртээмж сул, ил тод байдал дутмаг.

### Хэрэгжүүлэх ажлууд:

- 7.1. Удифлагын мэдээллийн санг шинэчлэх
- 7.2. Мэдээллийн санг бүрдүүлэх, өргөтгөх
- 7.3. Удифлагын мэдээллийн системийн талаар сургалт хийх, чадавхийг бэхжүүлэх
- 7.4. Олон нийтэд мэдээллийн системийг сурталчлан таниулах

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Төсвийн бүх ерөнхийлөн захирагч нар, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд

**Хэрэгжүүлж эхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

Зорилт	Тодорхой байдал				НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал	Боломжит үр нэлээ				Хэрэгж сэн байдал	Дуна хугацаа Эцсийн хугацаа	Засгийг нээлттэй болгосон үү?				
	Үгүй	Бага	Дуна	Их		Үгүй	Бага	Дуна	Томоохон							
7. Ерөнхий дүн	✓	✓	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж Иргэдийн оролцоо Төрийн хариуцлагатай байдал Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчлэл	✓	✓	Дуна	Томоохон	✓	Эхлээгүй	Агуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг Томоохон Дордвитой



## Зорилго

Олон улсын байгууллагаас авсан зээл, тусlamж, төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох. Үүний тулд шинэчилсэн, сайн удирдлагын мэдээллийн санг бий болгож, олон нийтэд сурталчлан таниулах.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Эхлээгүй

Одоогоор odamis.mof.gov.mn мэдээллийн санд хэрэгжиж дууссан болон одоо хэрэгжиж буй 1200 гаруй гадаадын зээл, тусlamжийн төслийн жагсаалт байна.<sup>1</sup> Төслийн эхлэх ба дуусах хугацаа, салбарын нэр, төслийн төлөв, хэрэгжих газар, санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч байгууллагын нэр зэргээр хайлт хийн ангилан харах боломжтой. Гэвч өмнөх YAYT-ний хэрэгжилтийн хугацаанаас хойш ямар мэдээлүүд нэмэгдсэн нь тодорхойгүй байна.

Мэдээллийн системийн талаарх сургалт зохион байгуулагдаагүй бөгөөд олон нийтэд сурталчлан таниулах ажил хийгдээгүй. YAYT-ний эхний жилд энэхүү зорилт хэрэгжиж эхлээгүй болно. (7.1-7.4) Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>2</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

odamis.mof.gov.mn мэдээллийн сан ерөнхий мэдээлэлтэй байсан хэвээр байна. Оруулсан төслийн тоо нэмэгдсэн ч дэлгэрэнгүй санхүүгийн мэдээлэл бүхий төслийн тайлангууд ихэнхдээ тавигдаагүй байна. (7.1,7.2) Мөн сургалтууд зохион байгуулагдаагүй болно. (7.3,7.4)

### Засгийг нээлттэй болгосон уу?

#### Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг

odamis.mof.gov.mn -д оруулсан мэдээлэл бага зэрэг нэмэгдсэн ч гадаадын зээл, тусlamжийн талаарх санхүүгийн дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг байна. Тийм учраас мэдээлийн хүртээмж бага зэрэг өөрчлөгдсөн болно.

### Дараагийн YAYT-д орсон уу?

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р YAYT-д үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> Гадаадын зээл тусlamжаар хэрэгжсэн, хэрэгжиж буй төслийн жагсаалт:

<https://odamis.mof.gov.mn/projectList>

<sup>2</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

## **8. НӨАТ-ЫН ЦАХИМ БҮРТГЭЛ**

### **Зорилт:**

Нийт худалдаа, үйлчилгээ эрхлэгч болон зах худалдааны төвүүдийг цахим төлбөрийн баримтын системд үргэлжлүүлэн бүртгэх, иргэд, аж ахуй нэгжүүдээг системтэй мэдээлэл түгээх.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

2015 оны 7-р сарын 9-ний өдөр Улсын Их Хурлаар НӨАТ-ЫН тухай хуулийг шинэчлэн баталснаар НӨАТ-ЫГ бүрэн гүйцэг ногдуулах, хураах хууль эрхзүйн орчин үүсч НӨАТ төлөгч хувь хүмүүс нь худалдаа, үйлчилгээний төлбөрийн баримтуудаа бүртгэлжүүлэн тухайн төрлийн төлсөн татваараасаа тодорхой хэмжээгээр урамшуулал, сугалаа хэлбэрээр буцаан авах боломжийг бий болгосон.

ТЕГ-аас олон улсын стандарт шаардлагыг хангасан “EBARIMT” системийг 2016 оны I сарын I-ний өдөрөөс хэрэгжүүлж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар 2016 оны I, 2-р сарын улсын төсөвт төвлөрүүлэх НӨАТ-ЫН ногдол дүн өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дундажаар 2,2 дахин өссөн байна.

2016 оны I-р сарын I-нээс буюу хууль хэрэгжсэн өдөрөөс өнөөдрийг хүртэл 29,880 худалдааа үйлчилгээ эрхлэгч ААН, иргэний 37,045 кассын машин холбогдсон байна. Энэ нь Монгол Улсын хэмжээнд бэлэн бус гүйлгээг бүртгэхийн тулд 1995 оноос өнөөдрийг хүртэл холбосон 12,000 ширхэг банкны ПОС-той харьцуулахад З хүрэхгүй сарын хугацаанд 37,045 ширхэг кассын ПОС-ыг татварын системд холбоог байгаа нь үнэмлэхүй амжилт юм.

Цаасан падаанаас цахим падаанг шилжснээр аж ахуй нэгжүүдийн хоороонд хийгдэж буй худалдааны процессыг татварын системд тайлагнахад илүү хялбар болж, татварын хяналт шалгалтын дарамт багасах боломж бүрдсэн. Жилд улсын төсөвөөс цаасан падаанг 300 орчим сая төгрөг төсөвлөдөг байсныг зогсоосон.

Ebarimt.mn цахим хуудасны хандалтын тоо нь 2016 оны 5-р сарын байдлаар 4,5 саяг хүрч, 415 493 тооны хүн баримтадаа бүртгүүлдэг болсноор Facebook, YouTube-н дафнаа орох Монгол Улсын топ вебсайтаар шалгархаад байна. <https://www.similarweb.com/country/mongolia>

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

8.1. Нэг талаас бараа, үйлчилгээ худалдан авч байгаа иргэд Цахим бүртгэлд яаж хамрагдах аргуудыг тусгасан, энгийн ойлгомжтой гафын авлагын төсөл бэлтгэж, иргэний нийгмийн байгууллагаар хэлэлцүүлэх.

8.2. Гафын авлагыг түгээх сувгуудаа тодорхойлж, бэлдэх /цахим, хэвлэмэл, мессеж, радио ТВ нэвтрүүлэг, сошиал медиаад зориулсан/.

8.3. Иргэдтэй зөвшилцөж, сайжруулсан гафын авлагаа суваг бүрээр түгээх.

8.4. Нөгөө талаас худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээг НӨАТ-ЫН тухай, баримтадаа хэзээ, яаж бүртгүүлж үйлчлүүлэгчид өгөх аргуудыг тусгасан энгийн, ойлгомжтой гафын авлагыг хэлбэр бүрээр, суваг бүрээр гафгах, түгээх.

8.5. Нягтлан бодогч нафт зориулсан НӨАТ-ЫН сургалтууг төв суурин, хөдөө орон нутагт хүргэх.

8.6. НӨАТ-ЫН цахим бүртгэлийн үр өгөөжтэй байдлыг тогтмол хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр мэдээлэх.

8.7. Сугалааны шинэчлэгдсэн жуфмыг олон нийтэд танилцуулах.

8.8. Сугалааны үйл явцыг олон нийтэд шууд хүргэх.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гааль, татварын ерөнхий газар

**Хамтран ажиллах байгууллага:** Төрийн бүх байгууллагууд, Гааль, татварын мэдээллийн технологийн төв, Үндэсний дата төв УТҮГ, Иргэд, ААНБ-үүд, ТББ-үүд, МҮХАҮТ, Монголын Эдийн Засгийн Форум

**Хэрэгжүүлж эхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал			Боломжит үр нэлээ		Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон үү?						
	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчлэл	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Аутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдээгүй	Бага зэрэг	Томоохон
Зорилт	Үгүй	Бага	Дуна	Их	✓	✓			✓						✓		✓			
8. Ерөнхий дүн			✓		✓	✓				✓										✓

### Зорилго

НӨАТ-ын цахим төлбөрийн баримтын бүртгэл, түүнтэй холбоотой мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүртээмжтэйгээр түгээх. Иргэдтэй зөвшшилцөж, сайжруулсан гарын авлагаяа суваг бүрээр түгээх.

### Хэрэгжсэн байдал

#### Дунд хугацаа: Ихэнх нь

2016 оны 9 сард НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой татвар төлөгчдөд зориулсан гарын авлагыг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөр хэлэлцүүлсэн. (8.1) ТЕГ И-баримт системийг танилцуулах мэдээллийг телевизийн 5 суваг, өдөр тутмын 2 сонин, мэдээллийн 2 цахим сайтаар цацсан байна. 2017 оны 4-р сар гэхэд худалдаа, үйлчилгээний

газруудаар “НӨАТ-ын буцаалт, сугалаа, баримтаа аваарай” сурталчилгааны плакат 28300 ширхэг нааж тараасан. Энэхүү тайланг бичих үед улс орон даяар бүх аймаг, хотуудыг хамруулан НӨАТ-ын тухай хууль, Е-баримт системийг хэрхэн ашиглах тухай нийт 2023 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. (8.2-8.5)

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>1</sup>

### **Эцсийн хугацаа: Бүрэн**

2018 оны 5-р сарын 31-ний байдлаар 88000 пос машинаар НӨАТ-ын баримтыг авч болж байв. 2017 оны байдлаар 247 сая баримт олгогдож, татвар төлөгчдөд 52,6 тэрбум төгрөгийн НӨАТ-ын буцаан олголт хийгджээ.<sup>2</sup> 2016 оноос 2018 оны эхний хагас хүртэл улсын төсөвт орох НӨАТ-ын орлого тасралтгүй өссөн. Нийт 900 000 татвар төлөгчдөөс 620 000 нь и-баримт системд бүртгүүлсэн байна.

Бизнес эрхлэгчид, нягтлан бодогчид, иргэдэд зориулсан сургалтууд тогтмол зохиогдож байлаа. (8.5) И-баримт системийн талаар мэдээллийн олон төрлийн сувгуудаар цацагдсан болно. (8.6) И-баримт систем нь Монгол улсад фейсбуук, твиттерийн дараа орох 3 дахь их хандалттай цахим хуудас боллоо.<sup>3</sup> (8.7,8.8)

ҮАҮТ-ний хоёр дахь жилийн төгсгөлд энэхүү зорилтыг бүрэн хэрэгжсэн гэж үзэж байна.

### **Засгийг нээлттэй болгосон уу?**

#### **Мэдээллийн хүртээмж: Томоохон**

#### **Иргэдийн оролцоо: Бага зэрэг**

Иргэд, ААН-үүд өөрсдийн төлсөн НӨАТ-ийн татварын мэдээллээ хялбар замаар мэддэг болсон. Татвар төлөгчид хэдийн хэмжээний НӨАТ төлсөн, хэдий хэмжээний буцаан олголт авахаа хянах боломжийг бүрдүүлсэн. НӨАТ-ын талаарх гарын авлагыг олон сувгаар түгээж, холбогдох сургалтуудыг зохион байгуулсан. Тийм учраас мэдээлийн хүртээмжийн хувьд томоохон өөрчлөлт гарсан байна.

Гарын авлагыг иргэний нийгмийн оролцоотой боловсруулсан ч иргэний нийгмийн төлөөлөлд санал, зөвлөмжөө өгөх хангалттай техникийн мэдлэг, чадвар байсан эсэх нь тодорхойгүй байна. Гарын авлагыг холбогдох мэргэжилтэнүүд боловсруулан гаргасан бөгөөд ТЕГ-с иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгээс дорвитой шинэ зөвлөмж гаралгүй болно. Тийм учраас иргэний оролцоог бага зэрэг гэж үзлээ.

### **Дараагийн ҮАҮТ-д орсон уу?**

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р ҮАҮТ-д үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>2</sup> <https://www.mongolchamber.mn/mn/newsDetail/1122>

<sup>3</sup> C.de Gruben. 3 things that Mongolia (probably) does better than the rest of the world  
<http://www.degruben.com/3-things-that-mongolia-probably-does-better-than-the-rest-of-the-world/>

## **9. Шилэн дансны системийг сайжруулах**

### **Зорилт:**

Төрийн байгууллагын төсөв санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгувр үзүүлэлтийг сайжруулж боловсронгуй болгох, иргэд иргэний нийгмийн байгууллагын санал, гомдолд хариу илгээдэг байх.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үйл явцад Шилэн дансны тухай (2014) хуулийн хэрэгжилтэд чухал үр нөлөө өгч байгаа өгөөг төрийн бүх байгууллага төсвийн зафцуулалтын мэдээллээ ил тод болгох механизм ажиллаж эхэлсэн. Үүний хэрэгжилтийг улам сайжруулж, ялангуяа орон нутагт төсвийн зафцуулалтаяа хуваан 5 сая төгрөгнөөс доош хэмээн бичиг баримт бүрдүүлж байна гэсэн иргэд, иргэний нийгмийн хардлага өндөр байгаа тул төсвийн байгууллагын орлого, зафлагын гүйлгээг ил тод болгох босгыг 1 сая болгох шаардлагатай байна.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

9.1. Шинэчлэн сайжруулсан Шилэн дансны цахим системийг олон нийтэд тасралтгүй, тогтмол сүрталчлах.

9.2. Төсөв, санхүүгийн 5 саяас дээш үнийн дүнтэй гүйлгээний мэдээллийн хамт тэрхүү гүйлгээний шийдвэр, үндсэн гэрээ хэлэлцээрийн мэдээллийг цахим хуудсанг мөн байршуулдаг болгох.

9.3. Орон нутгийн иргэд өөрсдөө хянаж, санал хүсэлтээ орон нутагтаа илгээж, хариу авдаг механизм судлан гафгах.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Төсвийн бүх ерөнхийлөн захирагч, Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд, “Иргэд төсвөө хянана” ТББ-ын сүлжээ, Хяналт-мониторинг хийдэг ТББ-ууд, МҮОНРТелевиз, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвсэл, МҮХАЙТанхим

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал				Боломжит үр нөлөө		Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?						
	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчлэл	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Адорвитой
Зорилт					✓						✓										
9. Ерөнхий АУН			✓		✓														✓		

## Зорилго

Шилэн дансны системд гүйлгээний шийдвэр, гэрээ хэлэлцээрийг байршуулж олон нийтэд илүү нээлттэй болгох. Ил тод болгох төсөв, санхүүгийн гүйлгээний үнийн дүнгийн доод хязгаарыг буулгах, орон нутгийн иргэд өөрсдөө хянаж, санал хүсэлтээ илгээж, хариу авдаг механизм судлан гаргах.

Шилэн дансны тухай 2015 оны I-р сараас эхлэн хэрэгжиж эхэлсэнээр төрийн бүх байгууллага төсвийн зарцуулалтын мэдээллээ олон нийтэд ил тод болгох шаардлагатай болсон.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Эхлээгүй

Шилэн дансны хуулийн дагуу төрийн бүх байгууллагууд төсвийн мэдээллээ Шилэн дансны системд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) 2015 оноос эхлэн оруулах болсон. Хэдийгээр төрийн байгууллагууд холбогдох мэдээллээ сар тутам оруулж байгаа боловч Шилэн дансны системд байгаа мэдээллийн төрөл өмнөх YAYT-ний хэрэгжилтийн үеэс өөрчлөгдөөгүй байна. (9.1)

Засгийн газраас зүгээс иргэд олон нийт хяналт тавьж, санал хүсэлтээ илгээн, хариу авах механизмыг бүрдүүлээгүй. Мөн ил тод болгох гүйлгээний доод босгыг I сая төгрөг болгоогүй байна. (9.2,9.3)

2017 оны эхний хагаст ННФ-ийн зүгээс орон нутагт болон зарим төрийн өмчит ААН-үүдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар мониторинг хийсэн болно.<sup>1</sup> Энэхүү мониторингийн судалгаагаар хуулийн хэрэгжилт 2016 оны эхний хагасыг дуустал хангалттай сайн байсан бол УИХ-ын сонгууль явагдсаны дараа 2016 оны сүүлийн хагаст суларсан байна.<sup>2</sup>

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>3</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

2018 оны 6-р сарын 27-нд Сангийн яамнаас гаргасан шилэн дансны тухай видео сурталчилгаанд<sup>4</sup> зөрчил, дутагдал илэрвэл дараахь арга замаар санал, гомдлоо гаргаж болно гэж зөвлөсөн байна.  
Үүнд:

- Цахим хуудас дээрх тухайн байгууллагын утсаар эсвэл бичгээр мэдэгдэнэ.
- Хэрэв тухайн байгууллага иргэний тавьсан шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гомдол, мэдээллийг төрийн аудитын байгууллагад гаргах эрхтэй.
- Төрийн аудитын байгууллага нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тухайн иргэнд бичгээр болон олон нийтэд мэдээлнэ.
- Эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

Энэхүү хяналтын систем нь одоо төрийн байгууллагуудын талаар гаргадаг санал, гомдлын механизмаас ялгарах зүйлгүй бөгөөд үр дүнтэй, шинэлэг байж чадахгүй байна. (9.3)

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт суларч эхэсэн учраас Үндэсний Аудитын Газраас төсвийн 100 гаруй байгууллагад хуулийн хэрэгжилтийг хангах талаар хугацаатай даалгавар өгсөн. Мөн Сангийн яамнаас хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлийг орон нутгийн төрийн сангүүдад өгсөн болно.<sup>5</sup> (9.1) Ил тод болгох гүйлгээний доод босгыг 1 сая төгрөг болгоогүй байна.

### **Засгийг нээлттэй болгосон уу?**

#### **Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг**

#### **Төрийн хариуцлагатай байдал: Бага зэрэг**

Шилэн дансны системд гүйлгээний шийдвэр, гэрээ хэлэлцээрийг байршуулаагүй. Ил тод болгох гүйлгээний доод босгыг 1 сая төгрөг болгоогүй. Харин шилэн дансны талаар видео сурталчилгаа болон санал, гомдлоо хэрхэн гаргах тухай зөвлөмжийг гаргасан. Энэ нь төр, засгийн мэдээллийг иргэдэд хүргэхэд бага зэргийн өөрчлөлтийг авчирсан болно.

Хэдийгээр зарим талаар тодорхой бус, үр дүнтэй эсэх нь эргэлзээтэй ч иргэдэд санал, гомдлоо гаргах механизмийг бий болгож түүнд нь төр, засгийн холбогдох байгууллагын зүгээс хариу өгөхийг үүрэг болгосон. Тийм учраас энэ зорилт нь төрийн хариуцлагатай байдал бага зэрэг дээшлүүлсэн гэж үзэж байна.

### **Дараагийн YAYT-д орсон уу?**

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р YAYT-д үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> Нээлттэй Нийгэм Форум. Жилийн тайлан 2017.

<sup>2</sup> Нээлттэй Нийгэм Форум. Жилийн тайлан 2017. 55-р хуудас.

<sup>3</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>4</sup> Сангийн яам. Шилэн данс. <https://www.youtube.com/watch?v=hmiyNW6bRbg>

<sup>5</sup> ННФ жилийн тайлан 2017. 55-р хуудас.

## **10. Засгийн газрын худалдан авах ажиллагааг нээлттэй болгох**

### **Зорилт:**

Олон улсын санаачлага болох Нээлттэй гэрээний дата стандафтыг Засгийн газрын худалдан авалтын үйл ажиллагааны бүрэн нэвтрүүлэх.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Сангийн Яам болон Худалдан авах ажиллагааны газрын (ХААГ) санаачлага, идэвхтэй үйл ажиллагааны үр дүнг төрийн болон орон нутгийн өмч, хөфөнгөөр баарга үйлчилгээ худалдан авах үйл явцыг нээлттэй болгох хүрээнд Монгол улс ихээхэн амжилт гафасан. Төрийн болон орон нутгийн өмч, хөфөнгөөр баарга, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2011 болон 2014 онуудаг дэвшилтэй өөрчлөлтүүд орж, мөн худалдан авах үйл ажиллагааг нээлттэй болгох онлайн платформ ашиглаж эхэлсэн.

Одоогийн онлайн платформыг бүрэн шинэчилж, худалдан авах үйл ажиллагааг бүрэн нээлттэй, тунгалааг мөн олон нийтэд мэдээлэл авах боломж, тэдний бүтээлч оролцоог дэмжсэн онлайн системийг бий болгохоор ХААГ ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагаагаа Сангийн яам, ХААГ, олон улсын санаачлага болох Нээлттэй гэрээний дата стандафтийн уялдуулж хөгжүүлэхийг Дэлхийн Банкнаас хүссэн бөгөөд эдгээр байгууллагууд энэ хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж байна.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

**10.1.** Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсаар дамжуулан тендерийн үрилга, үр дүнг олон нийтэд мэдээлэх.

**10.2.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөфөнгөөр баарга, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.9-г заасны дагуу захиалагч наф эрх үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих.

**10.3.** Төсвийн ерөнхийлөн захирагч нарын жил бүрийн худалдан авалтын төлөвлөгөө, тайлан болон үнэлгээг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэх.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Худалдан авах ажиллагааны газар, бүх яам, агентлаг, Дэлхийн банк, ИНБ-үүд болон хувийн хэвшил

**Хэрэгжүүлж эхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал		Боломжит үр нэлөө		Хэрэгж сэн байдал		Дуна хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?								
Зорилт	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдал байдлыг сайжруулах технologийн шинэчлэл	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Аутуу	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдээгүй	Бага зэрэг	Томоохон	Додвийтой
10. Ерөнхий дүн			✓		✓						✓			✓					✓		

## Зорилго

Нээлттэй гэрээний дата стандартыг засгийн газрын худалдан авалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, иргэд олон нийтэд нээлттэй ил тод болгох. Энэ ажлын хүрээнд цахим хуудсаар дамжуулан тендерийн урилга, жил бүрийн худалдан авалтын төлөвлөгөө, тайлан болон үнэлгээг олон нийтэд мэдээлэх.

## Status Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Эхлээгүй

Төрийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХБАҮХАТХ)<sup>1</sup> худалдан авалтын ил тод байдлыг хангадаг.

Засгийн газар тендерийн зар, гэрээний дүн, оролцогч талууд болон үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) -д нийтэлдэг. Мөн худалдан авалт хийх байгууллага тендерийн урилгаа үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн сувгаар зарладаг. Дунд хугацаанд зорилтыг хэрэгжүүлэх шинэ ажил хийгдээгүй ба худалдан авалтын цахим хуудсанд шинэ функц нэмэгдээгүй. (10.1-10.3)

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>2</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

Тендерийн зар, гэрээний дүн, оролцогч талууд болон үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) -А үргэлжлүүлэн нийтэлж байв. (10.1) Мөн худалдан авалтын төлөвлөгөө, үнэлгээ, хэрэгжүүлэлт болон хяналтын талаар мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) -с авах боломжтой. Засгийн газраас худалдан авалтын төлөвлөгөө, үнэлгээг цаг хугацаанд багтааж ил тод зохион байгуулах байдлыг чангатгаж сайжруулах тогтоол батлан гаргасны дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам 2018 он гэхэд бүх худалдан авалтаа онлайнаар зохион байгуулна гэдгээ мэдэгдсэн.<sup>3</sup>

2017 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсыг Нээлттэй гэрээний дата стандартын дагуу machine-readable форматтай болгон шинэчилсэн.<sup>4</sup> 2018

оны 1-р сарын 1-нээс эхлэн засгийн газрын худалдан авах гэрээнүүдийн жагсаалтыг оруулсан боловч гэрээнүүд нь тавигдаагүй байна. Тавигдсан тендерийн зарын тоо нэмэгдсэн.

ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.9-ийн дагуу гүйцэтгэж байгаа ажил, байршил, гэрээний үнийн дүн, ажил эхлэх, дуусах хугацаа зэргийг багтаасан мэдээллийн самбарыг олон нийтэд нээлттэй байдлаар байрлуулах ёстой.<sup>5</sup> Энэхүү заалтыг хянасан тайлан тайлант хугацааны эцэст гараагүй байна. (10.2)

Засгийн газрын худалдан авалтын гэрээ болон үнэлгээнүүд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудсанд тавигдсан байна <https://www.pcsp.gov.mn/f/20>. (10.3) Гэвч яамд, агентлагууд болон аймгуудаас ирсэн сүүлийн жилүүдийн худалдан авалтын тайлан тавигдаагүй байна.

## **Засгийг нээлттэй болгосон уу?**

### **Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг**

Энэ зорилтын хүрээнд Нээлттэй гэрээний дата стандартын дагуу засгийн газраас гаргаж буй худалдан авалтын тендерийн мэдээлэл нэмэгдсэн. Гэвч мэдээллийн шинэ төрөл, чиглэл хязгаарлагдмал байгаа тул мэдээллийн хүртээмж бага зэрэг сайжирсан гэж үзлээ.

## **Дараагийн YAYT-д орсон уу?**

Энэхүү зорилт нь Монгол улсын 3-р YAYT-д үргэлжлэн ороогүй.

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль <https://www.legalinfo.mn/law/details/493>

<sup>2</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>3</sup> Транспэрэнси Интернэшнл Монгол. Шударга бизнес Монгол улсын хөтөлбөр 2018. 52-р хуудас. <https://bit.ly/2AyA2zu>

<sup>4</sup> Ухаалаг засаг төсөл. Монгол улсын нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ. 2018 оны 8-р сар. [http://www.smart.gov.mn/wp-content/uploads/2019/02/ODRA\\_report\\_mon.pdf](http://www.smart.gov.mn/wp-content/uploads/2019/02/ODRA_report_mon.pdf)

<sup>5</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. <https://www.legalinfo.mn/law/details/493>

## **II. Нийтийн баялгийг ашиглах гэрээний ил тод байдал**

### **Зорилт:**

Монгол улсын нийтийн баялагт ашигт малтмал, газрын тос, газар, ус зэргээр ямар хүрээнд юуг хамруулан ойлгох тухай иргэд, иргэний нийгмийн оролцоотой тодорхойлох, тэдгээртэй холбоотой орж ашиглах, хөрөнгө оруулалт, тогтвржилт, хувь эзэмших, бүтээгдэхүүн хуваах, тэдгээрийн нэгэн агуулт гэрээ, орон нутгийн хамтын ажиллагаа, түүнтэй агуултгах гэрээ, газар, ус ашиглах гэрээ баримт бичгүүдийн төрлийг тогтоох, гэрээ, баримт бичгийн өгөгдлийн бааз бүрдүүлэх, олон нийтэд хүргэх.

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Нийтийн баялгийг ашиглахад баялгийн өмчлөлийг хэрэгжүүлэгч төр, тус баялгийг ашиглах аж ахуйн нэгжийн хоффондын харилцааг зохицуулагч баримт бичгүүдийн ил тод байдлыг хангах нь хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, баялгийн ашиглалтанд төр, иргэдийн зүгээс хяналт тавих нөхцлийг хангахад нэн чухал ач холбогдолтой юм. Ялангуяа газар, ус, эрдэс баялаг зэрэг нийтийн баялгийн ашиглалтын ил тод байдлыг хангах нь тэргүүн ээлжийн хэрэгцээ болоод байна.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

#### **II.I. Хамрах хүрээ буюу холбогдох нийтийн баялгийг тодорхойлох**

- a. Ашигт малтмал, газрын тос
- b. Газар, ус

#### **II.2. Хамрах гэрээний төрлийг тодорхойлох**

- a. Орж ашиглах, хөрөнгө оруулалт, тогтвржилт, хувь эзэмших, бүтээгдэхүүн хуваах, тэдгээрийн нэгэн агуулт гэрээ
- b. Газар, ус ашиглах гэрээ
- c. Орон нутгийн хамтын ажиллагаа, түүнтэй агуултгах гэрээ

#### **II.3. Гэрээний өгөгдлийн бааз бүрдүүлэх**

#### **II.4. Гэрээний өгөгдлийг олон нийтэд хүргэх**

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,

Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Газрын тосны Хэрэг эрхлэх газар, Ашигт малтмалын газар, Нээлттэй Нийгэм Форум

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал	Боломжит үр нэлөө				Хэрэгж сэн байдал	Дунд хугацаа Эцсийн хугацаа	Засгийг нээлттэй болгосон уу?									
	Үгүй	Бага	Дунд	Их		Үгүй	Бага	Дунд	Томоохон												
Зорилт					Мэдээллийн хүртээмж																
II. Ерөнхий АУН			✓		✓ ✓	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчэл	Үгүй	Бага	Дунд	Томоохон	Эхээгүй	Агуул	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Додвийт

## Зорилго

Нийтийн баялагийг ашиглах гэрээнд хамрах баялаг, гэрээний төрлийг тодорхойлох, гэрээний өгөгдлийн бааз бүрдүүлэх зэрэг замаар ил тод байдлыг хангах.

2017 оны байдааар олборлох салбар ДНБ-ий 23.4%, экспортын 79.6%-г эзэлж байна.<sup>1</sup>

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Ихэнх нь

2017 оны эхээр Нээлттэй Нийгэм Форум, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОҮИТБС) ажлын алба хамтран эрдэс баялагийн гэрээний мэдээллийн санг (<http://www.iltodgeree.mn/>) нээсэн. (II.1-II.3) Мэдээллийн санд I бүтээгдэхүүн хуваах, 22 хамтын ажиллагааны, 7 газар болон усны нөөц ашиглах зэрэг нийт 35 гэрээ тавигдсан байна. 2017 оны 6 сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОҮИТБС) ажлын алба болон Нээлттэй Нийгэм Форумын хооронд байгуулсан санамж бичгийн дагуу ОҮИТБС мэдээллийн санг ажиллуулах, шинэчлэх, УУХҮЯ төрийн байгууллагуудаас гэрээнүүдийг цуглуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн.<sup>2</sup>

ОҮИТБС 2-р баталгаажуулалтын тайландаа (2018 он) Монгол улсын гэрээг ил тод болгож байгаа үйл явцыг “хангалттай” гэж дүгнэсэн байна.<sup>3</sup> (II.4)

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>4</sup>

### Эцсийн хугацаа: Бүрэн

2018 оны 9-р сарын байдааар [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn) цахим хуудсанд 274 гэрээ тавигдсан байгаа нь Хараат бус явцын тайлангийн үеэс 8 дахин нэмэгдсэн байна. Мөн 140 гэрээний заалтын тайлбар

байна.<sup>5</sup> (II.I-II.4) Гэвч голлох хөрөнгө оруулалтын болон бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд тавигдаагүй байна.

## **Засгийг нээлттэй болгосон уу?**

### **Мэдээллийн хүртээмж: Томоохон**

#### **Иргэдийн оролцоо: Бага зэрэг**

Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд 274 гэрээ тавигдсан нь мэдээллийн хүртээмжийг ихээхэн нэмэгдүүлсэн байна. Олборлох салбар эдийн засагт нь томоохон байр суурь эзэлдэг Монгол улсын хувьд энэ нь чухал ач холбогдолтой юм. Хэдийгээр тавигдсан гэрээний тоо өссөн ч хөрөнгө оруулалтын болон бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг түлхүү тавих хэрэгтэй байна.

УУХҮЯ, ОҮИТБС-ын ажлын алба болон Нээлттэй Нийгэм Форумын хооронд гэрээнүүдийг цуглуулах, мэдээллийн санг ажиллуулах, шинэчлэх чиглэлээр төр, иргэний нийгмийн үр дүнтэй хамтын ажиллагаа явагдаж байна. Цаашид шийдвэр гаргах үйл явцад илүү олон иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах хэрэгтэй.

## **Дараагийн YAYT-д орсон уу?**

Монгол улсын НЗТ-ийн З-р YAYT-д II-р зорилт: Гэрээний ил тод байдлыг хангах болж орсон. Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай бие даасан хууль гаргах болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах боломжуудыг судлан шаардлагатай тооцоо, судалгаа, үнэлгээг хийх, эрх зүйн орчин бүрдүүлэх; [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn) цахим хуудсыг тогтмол, тогтвортой хариуцан ажиллуулах үүргийг УУХҮЯ, АМГТГ, ОҮИТБС-ын ажлын албандааатгах эрх зүйн орчныг бүрдүүлэх; байгалийн баялаг ашиглах гэрээ нь Захиргааны ерөнхий хуулиар захиргааны гэрээ болж байгааг гэрээний талуудад ойлгуулах, иргэдийн оролцоог хангах, хэрэгжилтэд үнэлгээ хийх нөлөөллийн ажил; хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дунд хугацааны болон эцсийн үнэлгээ хийх зэрэг орсон байна.

<sup>1</sup> Монгол улсын 12-р буюу 2017 оны тайлан. Монголын ОҮИТБС, 2018.

[http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/EITI\\_report\\_2017\\_mn.pdf](http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/EITI_report_2017_mn.pdf)

<sup>2</sup> ННФ-ийн хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэгийн 2018 оны 4-р сарын 23-ны өдөр судалгааны асуулгад хариулсан мэдээлэл.

<sup>3</sup> Монгол улсын ОҮИТБС-ын 2-р баталгаажуулалтын тайлангийн шаардлагыг хангасан байдал <https://eiti.org/mongolia#mongolias-progress-by-requirement>

<sup>4</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

<sup>5</sup> <http://www.iltodgeree.mn/>

## **12. Байгалийн баялгийг ашиглах этгээдийн эзний мэдээллийн ил тод байдал**

### **Зорилт:**

- Холбогдох байгалийн баялгийг тодорхойлох  
Ашигт малтмал, газрын тос, газар, ус
- Эзний тухай мэдээллийг цуглуулах механизмийг бүрдүүлэх
- Мэдээллийг нягтлан баталгаажуулах механизмийг бүрдүүлэх
- Мэдээллийг олон нийтэд хүргэх

### **Өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудлууд:**

Байгалийн баялгийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа нь баялгийн эзний хувьд ил тод байх нь хариуцлагын суурь зарчим билээ. Өнөөдөр энэ мэдээлэл тэр бүр ил тод байхгүй байгаа нь хяналт тавих, хариуцлага тооцох боломжийг хязгаарлаж байна.

### **Хэрэгжүүлэх ажлууд:**

12.1. Хамрах хүрээ буюу холбогдох байгалийн баялгийг тодорхойлох

a. Ашигт малтмал, газрын тос

b. Газар, ус

12.2. Эзний тухай мэдээллийг цуглуулах механизмийг бүрдүүлэх

12.3. Мэдээллийг нягтлан баталгаажуулах механизмийг бүрдүүлэх

12.4. Мэдээллийг олон нийтэд хүргэх

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,

Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**Хамтран ажиллах байгууллага:** Хууль зүйн эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, Гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Газрын тосны хэрэг эрхлэх газар, Ашигт малтмалын газар, Нээлттэй Нийгэм Форум, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага, Хил хязгааргүй алхам ТББ

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЗТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал				Боломжит үр нөлөө				Хэрэгж сэн байдал		Дунд хугацаа Эцсийн хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?				
	Үгүй	Бага	Дуна	Их	Мэдээллийн хүртээмж	Иргэдийн оролцоо	Төрийн хариуцлагатай байдал	Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинчилэл	Үгүй	Бага	Дуна	Томоохон	Эхлээгүй	Дуттуу	Ихэнх нь	Бүрэн	Муусан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвигийн
Зорилт					✓								✓								
12. Ерөнхий АҮН			✓		✓									✓					✓		

## Зорилго

Ашиг хүртэгч эздийн мэдээллийг цуглуулах замаар баягалийн баялгийг ашиглах этгээдийн эздийн мэдээллийг ил тод болгох.

Эрдэс баялгийн лиценз эзэмшигч компаниудын ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгох санаачлагыг иргэний нийгмийн зүгээс гаргасан. Олон нийт газрын харилцаа, уул уурхай, орон нутаг дахь худалдан авалтын салбарыг хамгийн их авилгад өртсөн үэж үздэг.<sup>1</sup> Олборлох салбар Монголын ДНБ-ий 23.4%-ийг эзэлдэг.

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Дутуу

Монгол улсын ОҮИТБС-ын 2016 оны нэгтгэл тайланд ОҮИТБС-ын Стандарт 2.5-ын дагуу боловсруулсан бенефициар өмчлөгчийн мэдээллийн хүсэлтийн маягтыг нэгтгэлд сонгогдсон 213 компаниудад хүргүүлсэнээс 47 компани (22%) л ОҮИТБС-ын цахим тайлангийн системд тайлагнасан байна.<sup>2</sup> Гэвч ажлын төлөвлөгөөний дагуу мэдээлэл цуглуулж олон нийтэд хүртээмжтэй болгох ажил 2019 оноос нааш хийгдэхгүй болно. (12.1-12.4)

2016-2017 онд төрийн байгууллагууд, олборлогч компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн оролцоотой ашиг хүртэгч эздийн талаар 9 удаагийн хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулсан. (12.1,12.2) Иргэний нийгмийн төлөөллийн мэдээлсэнээр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар 2018 оны 6-р сараас эхлэн уул уурхайн бүх компаниудаас ашиг хүртэгч эздийнх нь мэдээллийг авдаг болохоор ажиллаж байна.<sup>3</sup>

### Эцсийн хугацаа: Дутуу

Засгийн газрын зүгээс энэхүү зорилтыг хэрэгжүүлэх талаар тайлангийн үлдсэн хугацаанд ямар нэг ажил хийгээгүй. (12.1-12.4)

Гэвч иргэний нийгмийн зүгээс зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр хэд хэдэн ажил хийсэн. Болно. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн болон Ил тод байдлын сан ТББ хамтран 2018 оноос ашиг хүртэгч эздийн талаар <https://iltodezed.wordpress.com/> цахим хуудсыг ажиллуулах болсон.

Тайлант хугацааны төгсгөлд 50 орчим компанийй эзэмшдэг лиценз, үйл ажиллагаа, удирдлага, удирдах зөвлөл, ашиг хүртэгч эздийн талаарх мэдээлэл орсон байна. (12.4)

ОҮИТБС болон ННФ компаниудын төлөөлөл, УИХ-ын гишүүд болон бусад шийдвэр гаргагчид, иргэний нийгмийн төлөөлөлд зориулан ашиг хүртэгч эздийн талаарх ойлголтыг дээшлүүлэх цуврал сургалт, семинарууд зохион байгуулсан байна. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажлыг хялбаршуулахын тулд холбогдох хууль, тогтоомжинд нэмэлт өөрчлөлт оруулах талаар мөн хэлэлцүүлэг өрнөж байна.

## Засгийг нээлттэй болгосон уу?

### Мэдээлийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Хэдийгээр төр, засгийн төлөөлөл олборлох салбарын ашиг хүртэгч эздийн талаарх сургалт, хэлэлцүүлэгт оролцож байсан ч энэ чиглэлээр мэдээллийн сан үүсгэн мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хийгээгүй. Тийм учраас мэдээллийн хүртээмж өөрчлөгдөөгүй болно.

Хэдийгээр зорилтыг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гаргаагүй ч олборлох салбарын ашиг хүртэгч эздийн ил тод байдлыг хангах нь эзэмшигчдийн нуугдмал байдлыг арилгах, олон нийттэй итгэлцэл бий болгох, татвараас зугтах явдлаас урьдчилан сэргийлэх, авилгыг бууруулах сайн талуудтай. Энэхүү шинэчлэл нь хөрөнгө оруулагчдад тэгш нөхцөлийг бүрдүүлж, монголчуудад олборлох салбарын үр шимийг илүү хүртэх боломжийг олгоно.<sup>4</sup>

## Дараагийн YAYT-д орсон уу?

Монгол улсын НЭТ-ийн 3-р YAYT-д 10-р зорилт: Ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах болж орсон. Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудыг хамруулан хамтарсан уулзалт хийж ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бий болгох талаар уулзалт, хэлэлцүүлэг хийх; Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах, шаардлагатай тооцоо, судалгаа, үнэлгээг хийх, хуулийн төслийг батлах; эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуваж, нэгдсэн цахим санд байршуулж, нийтэд нээлттэй болгох; ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлын шаардлагыг холбогдох хуулийн этгээдүүд, бусад талуудад таниулах сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах; хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дунд хугацаанд болон эцсийн үнэлгээ хийх зэрэг орсон байна.

<sup>1</sup> Азийн сан, Сантмарал сан. Авилгын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа 2017, [https://asiafoundation.org/wp-content/uploads/2017/09/MG-SPEAK2017\\_MNG.pdf](https://asiafoundation.org/wp-content/uploads/2017/09/MG-SPEAK2017_MNG.pdf)

<sup>2</sup> Монгол улсын ОҮИТБС-ын нэгтгэлийн тайлан 2016 он: [http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/Mongolia\\_EITI\\_Report\\_2016\\_Mongolian.pdf](http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/Mongolia_EITI_Report_2016_Mongolian.pdf)

<sup>3</sup> ННФ-ийн хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэгийн 2018 оны 4-р сарын 23-ны өдөр судалгааны асуулгад хариулсан мэдээлэл.

<sup>4</sup> Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн. Н.Дорждарь. Resource Governance Index Points to State-Owned Enterprises as Key Mongolia Reform Target. September 29, 2017 <https://resourcegovernance.org/blog/resource-governance-index-points-state-owned-enterprises-key-mongolia-reform-target>

### **I3. Төрөөс компаниудын зөвшөөрөл, санхүү, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, шуурхай болгох**

#### **Зорилт:**

Компанийн санхүү болон үйл ажиллагааны тайланг нийтэд жил бүр гафгуулж хэвшигүүлэх, байгаль орчны нөлөөлөл, нийгмийн хариуцлагын тайлагналын ил тод байдлыг хангуулах нэгдсэн санг бүргүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоог нэмэгдүүлж, компаниуд өөрсдийн мэдээллийг түгээдэг, тайлагнадаг соёл бий болгож, засаглалын сурталчилгаа хийдэг болох, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг бие даасан болгох, нэр дэвшигчдийн мэдээллийг ил тод болгох, ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг улс төфөөс анги, бие даан шийдвэр гафгаж, хариуцлага хүлээх, гүйцэтгэлд тулгуурлан үнэлдэг тогтолцоонд шилжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх ажлууд:**

I3.1. Компанийн засаглалтай холбоотой мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ил тод, нээлттэй болгох нэгдсэн мэдээллийн тогтолцоог бүргүүлэх.

I3.2. Төрийн өмчимт компаниудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг нийцсэн тайлан гафгадаг болгох.

I3.3. Уул уурхайн салбарыг үйл ажиллагаа явуулдаг компаниудын байгаль орчны нөлөөллийг тайлагнасан нийгмийн хариуцлагын тайлан гафгуулдаг болгож, нээлттэй мэдээлэх нэгдсэн тогтолцоог бүргүүлэх.

I3.4. Төрийн ба нийтийн өмчимт компаниудын олборлох үйлдвэрлэлийн гэрээ, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлэлцэлүүдийг нээлттэй, ил тод тайлагнадаг болгох.

I3.5. Төрийн ба нийтийн өмчимт компаниудын үйл ажиллагаагаа тогтмол нийтэд сонсгох, мэдээлж тайлагнадаг болгох.

I3.6. Ил тод байдлыг хангуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслийн хариуцлагатай хамтын оролцоог бүх шатанд нэмэгдүүлэх.

I3.7. Төрийн өмчимт компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах зафыг нийтэд мэдээлдэг болж нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгож хараат бус, хөнгөнгүйн байгууллагын оролцоотойгоор тохиомжтой этгээдийн жагсаалтыг гафгуулан холбогдох компанийн нэр дэвшигүүлэх хороонон хүргүүлж тэднээс сонгогд болгох.

I3.8. Нийтийн өмчийн болон байгалийн баялгийг ашиглагч компаниудын жинхэнэ өмчлөгчдийн талаарх мэдээллийг нээлттэй болгох.

I3.9. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийг бие даан шийдвэр гафгаж ажилладаг болгох, гафгасан шийдвэртээ хариуцлага хүлээж чадаг байлах, улс төфөөс анги хараат бусаар ажиллах нөхцөл бололцоог бүргүүлэх, гүйцэтгэлд тулгуурлан үрамшуулах тогтолцоог нэвтрүүлэх.

#### **Хэрэгжүүлэгч байгууллага: Санхүүгийн зохицуулах хороо**

**Хамтран ажиллах байгууллага:** Төсөв, санхүү, Уул уурхай, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, Компанийн засаглалын үндэсний зөвлөл, МҮХАЙТ, Эрдэнэс МГЛ ХХК, Компанийн засаглалын Үндэсний портал сайт, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, МҮОНРТ-ийн Монголын радио, Үндэсний телевиз, Монголын мэдээ суваг

**Хэрэгжүүлж өхлэх огноо:** 2016.06.30

**Хэрэгжүүлж дуусах огноо:** 2018.06.30

**Редакцийн тайлбар:** Энэ нь зорилтын товчилсон хувилбар болно. Бүрэн хэмжээгээр нь Монголын YAYT-с үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2017/04/Mongolia-NAP2-Final.pdf>

	Тодорхой байдал				НЭТ-ийн үндсэн зарчмуудтай хамаарсан байдал	Боломжит үр нөлөө	Хэрэгж сэн байдал	Дунд хугацаа		Засгийг нээлттэй болгосон уу?	
	Үгүй	Бага	Дунд	Их				Эцсийн хугацаа			
Зорилт					Мэдээллийн хүртээмж Иргэдийн оролцоо Төрийн хариуцлагатай байдал Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах технологийн шинэчлэл	Үгүй	Бага	Дунд	Томоохон	Эхээгүй Дутуу Ихэнх нь	Муудсан Өөрчлөгдөөгүй Бага зэрэг Томоохон Дорвигтой
13. Ерөнхий АУН			✓	✓		✓	✓	✓	✓	✓	

## Зорилго

Энэхүү зорилт нь голчлон олборлох салбарын төрийн ба нийтийн өмчит компаниудад дахь ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, ил тод байдлыг сайжруулах. Мөн олборлох компаниуд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг биелүүлж байгаль орчны нөлөөллийн тайлангаа гаргах, төрийн өмчит компаниуд олон улсын стандартад нийцүүлэн тайлагналын чанараа сайжруулах. Нийгмийн хариуцлагын тайлан гаргах, ТУЗ улс төрийн нөлөөллөөс ангид ажилладаг байх. 2016 онд зөвхөн 7 төрийн өмчит компани л ТУЗ-ийн талаарх мэдээллээ ил болгосон байна.<sup>1</sup>

## Хэрэгжсэн байдал

### Дунд хугацаа: Дутуу

2015 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу төрийн өмчит компаниуд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг (СТОУС) мөрдөн биелүүлэх ёстой.<sup>2</sup> Хэдийгээр энэ хуулийг 2016 оны 1-р сараас мөрдэж эхэлсэн ч олонх компани зардал өндөр, мөн хялбар бус гэсэн шалтгаанаар дээрх стандартыг мөрдэж чадахгүй байна. 2016 оны 12-р сард Сангийн яамнаас нягтлан бодох бүртгэл, аудитын турван шинэ стандартыг СТОУС-д нийцүүлэн батлан гаргасан. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын

ерөнхий нягтлан бодогчид зэрэг нийт 90 гаруй хүнийг сургалтанд хамруулж шинэ стандартуудыг танилцуулсан болно. (13.2)

2011 онд батлагдсан Компаний тухай хуулиар нэр дэвшигүүлэх хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагаанд агуулж хийхээр зохицуулагдсан байдаг.<sup>3</sup> Хэдий тийм ч Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагын үзэж байгаагаар хамгийн том арван компани нэр дэвшигүүлэх хороогүй, ТУЗ-ийнхөө үйл ажиллагаанд тогтмол үнэлэлт дүгнэлт хийхгүй байна.<sup>4</sup> Мөн энэхүү зорилтонд багтсан ТУЗ-ийн ил тод байдалтай холбоотой бусад ажлууд хэрэгжсэн гэсэн мэдээлэл байхгүй болно. Тийм учраас хэрэгжүүлэх ажлын 13.7-д ахиц дэвшил гараагүй.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2016-2017 оны ХБТМ-ын явцын тайлангаас үзнэ үү.<sup>5</sup>

### **Эцсийн хугацаа: Дутуу**

YAYT-ний 2 дахь жилд хэрэгжилтэнд өөрчлөлт гараагүй. Сангийн яам 2018 онд төрийн өмчит компаниудын санхүүгийн тайлангийн чанарыг сайжруулах үүднээс СТОУС-ыг бүрэн орчуулж гаргасан. Гэвч төрийн өмчит хамгийн том компани болох Эрдэнэс Монгол СТОУС-ыг даган мөрдөж эхлээгүй байна.

Хэрэгжүүлэх ажлын 13.4 Зорилт 11-тэй, 13.8 Зорилт 12-той давхцаж байгаа тул хэрэгжилтийн тухай зохих зорилтуудын хэсгээс танилцана уу.

### **Засгийг нээлттэй болгосон уу?**

#### **Мэдээлийн хүртээмж: Бага зэрэг**

Ихэнх хэрэгжүүлэх ажлуудын хувьд ахиц дэвшил гараагүй тул энэхүү зорилт нь нээлттэй засгийн чиглэлд дорвitoй хувь нэмэр оруулаагүй. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалт нууцлаг байдлаар улс төрийн ихээхэн нөлөөтэй явагдаж байна. ТУЗ-ын бүх гишүүдийн ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг АТГ-аас шалган тогтоо ёстой ч энэ талаарх мэдээлэлийг ил тод болгоогүй. Компанийн засаглалтай холбоотой мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ил тод, нээлттэй болгох нэгдсэн мэдээлийн тогтолцоог бүрдээгүй. Нийгмийн хариуцлагын тайлан гаргадаг уул уурхайн компаниудын тоо нэмэгдээгүй.

Гэхдээ төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл санхүүгийн тайлагналын стандартын сургалтанд суусан. Энэхүү сургалт нь төрийн өмчит компаниудын санхүүгийн тайлангийн чанарыг сайжруулахад чиглэсэн тул мэдээлийн хүртээмж бага зэрэг сайжирсан гэж үзэж байна.

### **Дараагийн YAYT-д орсон уу?**

Монгол улсын НЭТ-ийн 3-р YAYT-д 9-р зорилт: Төрийн болон нийтийн өмчит компанийн засаглалыг сайжруулах болж орсон. Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон нийтийн өмчийн засаглалыг сайжруулах эрх зүйн орчинг сайжруулах; компанийн засаглалын ахисан түвшиний гэрчилгээ олгох мэргэшсэн сургалтыг бий болгож чадавхижуулах; төрийн болон нийтийн өмчийн засаглал, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангуулах; компанийн засаглалын хөндлөнгийн үнэлгээг хийж зөвлөмж өгөх, үр дүнг тайлагнах тогтолцоог бий болгох; ТУЗ, гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалтыг олон нийтийн оролцоонд тулгуурлан нээлттэй, ил тод зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бий болгох; төрийн болон нийтийн өмчит компанийн нийгмийн хариуцлага, дотоод аудит, эрсдэлд сууринсан хяналтын тогтолцоог бий болгох зэрэг орсон байна.

<sup>1</sup> Монгол улсын 12-р буюу 2017 оны тайлан. Монголын ОҮИТБС, 2018.

[http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/EITI\\_report\\_2017\\_mn.pdf](http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/EITI_report_2017_mn.pdf)

---

<sup>2</sup> Ernst & Young, "Mongolia's new Accounting and Auditing Laws", <https://www.ey.com/Publication/vwLUAssets/ey-mongolia-new-accounting-and-auditing-laws/%24FILE/ey-mongolia-new-accounting-and-auditing-laws.pdf>

<sup>3</sup> Компаний тухай хууль <https://www.legalinfo.mn/law/details/310>

<sup>4</sup> Транспэрэнси Интернэшнал Монгол. Шударга бизнес Монгол улсын хөтөлбөр 2018. <https://bit.ly/2AyA2zu>

<sup>5</sup> [https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia\\_Mid-Term\\_IRM-Report\\_2016-2018\\_MN.pdf](https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2018/09/Mongolia_Mid-Term_IRM-Report_2016-2018_MN.pdf)

## Аргачлал

НЗТ-ийн YAYT-ний эцсийн тайланг бичиг баримт, мэдээллийн судалгаа, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлага дээр үндэслэн гаргана. Мөн засгийн газрын өөрийн үнэлгээний тайлан, иргэний нийгэм, хувийн хэвшил болон олон улсын байгууллагуудаас гаргасан бусад үнэлгээ, өмнөх хараат бус үнэлгээний явцын тайланг ашиглана.

ХБТ-ын судлаач бичиг баримтын судалгаа болон ярилцлагауд хийсэн болно.

ХБТ-ын судлаач дараахь хүмүүсээс ярилцлага авсан. Үүнд:

- Д.Амарбаясгалан – Дэлхийн банкны МУНЭХБТ-ийн хамтран ахлагч, засаглалын мэргэжилтэн
- Г.Ундрал – Ардчиллын боловсрол төв ТББ-ын тэргүүн
- Д.Энхцэцэг – ННФ-ийн засаглалын хөтөлбөрийн менежер

ХБТын судлаач НЗТ-ийн YAYT-ний эцсийн тайланг бичих явцдаа ярилцлага авахын тулд засгийн газрын холбогдох ажилтануудтай утсаар болон имэйлээр холбогдохыг оролдсон боловч хариу аваагүй болно.

Мөн иргэний нийгмийн зүгээс 2-р YAYT-ний хэрэгжилтэнд хийсэн мониторингийн тайлан, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Холбооноос зохион байгуулсан НЗТ-ийн оролцогч талуудын уулзалтын тэмдэглэлийг ашигласан болно.

Энэхүү тайланг Монголын хараат бус тайлагналын судлаач Загдрагчаагийн Батболд ХБТМ-ын ажилтануудын дэмжлэгтэйгээр бичсэн болно.

Нээлттэй Засаг Түншлэл (НЗТ) нь засаглалыг сайжруулахын тулд ил тод байдлыг дэмжих, иргэдийг хүчирхэгжүүлэх, авлигатай тэмцэх, шинэ технологийг нэвтрүүлэхд чиглэсэн бодит зорилтуудыг дэвшүүлэх зорилготой. Хараат Бус Тайлагналын Механизм (ХБТМ) нь оролцогч талуудын дунд яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, хариуцлагатай байдлыг сайжруулахын тулд YAYT-г боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг үнэлэн дүгнэдэг.

